



Юнител группийн 2022 оны

Тогтвортой байдлын **ТАЙЛАН**

АГУУЛГА

Компани

БОНЗ хандлага.....	04
Оролцогч талуудын оролцоо.....	05

Байгаль орчин

Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах.....	07
Хог хаягдлын менежмент.....	10
Байгаль болон зэрлэг ан амьтдыг хамгаалах.....	12

Нийгэм

Олон талт онцлог болон ижил тэгш оролцоот байдал.....	15
Чадварлаг ажилтныг татах, тогтвортой ажиллуулах.....	18
Хөдөлмөрийн аюулгүй байдал.....	24
Сүлжээ болон мэдээллийн аюулгүй байдал.....	27
Цахим боловсрол ба ижил тэгш оролцоо.....	29
Үйлчилгээний хүртээмжтэй байдал.....	30
Нийгэмд тустай ажлууд.....	31

Засаглал

Засаглалын дээд түвшин.....	33
Сайн засаглал.....	34
Ханган нийлүүлэгчдийн менежмент.....	35

Тоо баримт

Тайлангийн тухай	37
GRI Index.....	38
ESG Metrics.....	44



КОМПАНИ

БОНЗ хандлага

Бид хэрхэн нөлөөлдөг вэ?

Юнител группийн тогтвортой байдлын хандлага нь найдвартай, дэвшилтэт харилцаа холбооны үйлчилгээгээр дамжуулан технологийн дэвшлээр нийгмийн тогтвортой хөгжилд түүштай, бодитой хувь нэмэр оруулахад чиглэнэ.

Тогтвортой байдал (БОНЗ)-ын хяналт

Манай бизнес болон оролцогч талуудын хувьд чухал ач холбогдолтойд тооцогдох БОНЗ-ын асуудлуудыг бид компанийн удирдах түвшинд авч үздэг билээ. Ингэснээр шийдвэр гаргах үеэр БОНЗ-ын асуудлуудыг нухацтай авч үзэх, компани доторх хамтын ажиллагааг сайжруулах боломжтой болох юм.

БОНЗ-ын хороо болон бусад 3 хороо улирал тутам хуралдаж, компанийн тогтвортой байдлыг зорилтын хэрэгжилтийг хянан хэлэлцдэг.

Байгаль орчин	Хүн
Байгаль орчинд үзүүлэх шууд нөлөөлөл болон нүүрсхүчлийн хийн ялгарлыг багасгах	Ажилтнуудаа эрүүл, аюулгүй, олон талт онцлог, ижил тэгш оролцоот байдлыг хангах

Олон нийт	Засаглал
Сайн үлгэр дуурайл үзүүлж, олон нийтийн сайн сайхан байдлыг дээшлүүлэх	Ёс зүйг дэмжиж байгууллагын хэмжээнд тогтвортой сэтгэлгээг сурталчлах

Засаглалын бүтэц

Юнителийн Төлөөлөн удирдах зөвлөл

Менежментийн үйл ажиллагааг хянаж, Юнител группийн үнэ цэнийг өсгөхөд чиглэсэн урт хугацааны болон стратегийн зөвлөгөө өгдөг. Мөн группийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээс гадна байгууллагын эрсдэл, мэдээллийн аюулгүй байдал болон БОНЗ-ын асуудлуудын талаар менежментийн баг болон ТУЗ-ийн хорооноос нэмэлт мэдээллүүдийг тогтмол авдаг.

Цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хороо	Аудит, эрсдэлийн хороо	Санхүү, хөрөнгө оруулалтын хороо	БОНЗ-ын хороо
Дээд удирдлагын цалин урамшууллын төлөвлөгөө болон цалин урамшууллын шатлалыг боловсруулна. (1 хараат, 2 хараат бус гишүүн)	Дотоод аудит, комплаенс болон эрсдэлийн удирдлага (1 хараат, 2 хараат бус гишүүн)	Богино болон урт хугацааны санхүүгийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон төлөвлөгөөний өөрчлөлтийг боловсруулна. (2 хараат, 1 хараат бус гишүүн)	БОНЗ болон нийгмийн хариуцлагын стратеги, үйл ажиллагааг тодорхойлно (1 хараат, 2 хараат бус гишүүн)

Гүйцэтгэх удирдлага

Юнител группийн удирдлагын баг нь БОНЗ-ын асуудлууд, эрсдэл болон шинэ санаачилгын хэрэгжилтэд хяналт тавьж, БОНЗ хороонд тайлан, мэдээ хүргэдэг. Гүйцэтгэх удирдлага нь компанийн хэмжээнд үйл ажиллагааны уялдаа холбоог бий болгож, нэгдсэн стратегийн удирдамж гаргаж, хэрэгжилтэд хяналт тавих, түлгарч буй асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор компанийн дотоод хороодыг хамтран удирдах үүрэгтэй.

Үндсэн чиглэл хоорондын гүйцэтгэх удирдлагын хороод

БОНЗ дотоод хороо
БОНЗ ажлын хэсэг

Оролцогч талуудын оролцоо

Манай бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөх оролцогч талууд нь хэрэглэгч, хувьцаа эзэмшигч, хамтрагч байгууллагууд, ажилтнууд болон олон нийт гэх мэт олон янз байдаг. Юнител групп нь бизнесийн үйл ажиллагааны хүрээнд оролцогч талууддаа шинэлэг, сэтгэл ханамжтай байдлыг бий болгохын тулд төрөл бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлдэг бөгөөд үр дүн нь зөвхөн тодорхой нэгж, чиглэлийн тайланд тусгагдахаас гадна холбогдох хороод, удирдлагын хуралд танилцуулагдаж, шийдвэр гаргах процесст нөлөөлдөг.

- **Хэрэглэгч**
Бид хэрэглэгчдийнхээ итгэлийг дааж, аюулгүй, үнэ цэнтэй бүтээгдэхүүн санал болгосноор сэтгэл ханамжийг бий болгоно.
- **Хувьцаа эзэмшигч ба хөрөнгө оруулагч**
Бид шударга, ил тод мэдээллээр хангаж, идэвхтэй харилцаа үүсгэх замаар итгэлцлийг бий болгохын төлөө ажилладаг.
- **Ажилтнууд**
Бид бүх ажилтнуудаа ажлын байр болон ажлын орчиндоо сэтгэл ханамжтай байлгахыг зорьдог.
- **Нийгмийн бүлэг**
Бид орон нутгийн болон бусад нутгийн нийгмийн бүлгүүдтэй хамтран ажиллаж, компанийн нийгмийн хариуцлагаа биелүүлдэг.
- **Зохицуулагч байгууллагууд**
Бид хуулийг дагаж мөрдөн, үйл ажиллагаагаа зөв зохистой байлгадаг.
- **Нийлүүлэгч**
Бид харилцан итгэлцэл дээр тулгуурласан түншлэлийн харилцааг бий болгож, шударга, нээлттэй, зохистой бизнесийн үйл ажиллагаа явуулдаг.

Оролцогч талууд		Харилцах арга	Давтамж	Агуулга
Хэрэглэгч	Бид харилцагчдынхаа итгэлийг олж, аюулгүй, үнэ цэнтэй бүтээгдэхүүн үйлчилгээ хүргэх замаар хэрэглэгчдээ сэтгэл ханамжтай байлгахыг зорьдог.	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, веб сайт болон нийтийн сүлжээнд мэдээлэх	Шаардлагатай тохиолдолд	Компани болон бизнесийн үйл ажиллагааны талаар мэдээлэл түгээх
		Харилцагчийн үйлчилгээний төвөөр дамжуулах	Шаардлагатай тохиолдолд	Хэрэглэгчийн санал хүсэлтэд хариу өгөх; бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сайжруулах зорилгоор хэрэглэгчдээс ирсэн санал хүсэлтийг компанийн хэмжээнд хуваалцах
		Салбар/жижиглэнгийн сүлжээгээр дамжуулах	Шаардлагатай тохиолдолд	
Хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид	Бид үнэн, зөв мэдээллийг дамжуулж, идэвхтэй харилцаа тогтоох замаар итгэлцлийг бий болгохын тулд ажилладаг.	ТҮЗ-ын хурал болон Хороодын хурал	Улирал тутам	Бизнесийн тайлан, санхүүгийн тайлан, аудитын тайланг танилцуулах
Ажилтнууд	Бид нийт ажилтнуудаа ажлын байр болон ажлын орчиндоо сэтгэл ханамж өндөр байлгахыг зорьдог	Ажилтнуудын оролцоо болон байгууллагын соёлын судалгаа	Жил бүр	Ажилтнуудаас судалгаа авах
		Удирдлага болон ажилтны хооронд санал солилцол	Шаардлагатай тохиолдолд	Хүний нөөцийн зохицуулалтын талаарх асуудлаар санал солилцож, харилцан ойлголцох
Орон нутгийн нийгмийн бүлэг	Бид орон нутгийн нийгмийн бүлэгтэй хамтран ажиллаж, компанийн хариуцлагаа биелүүлдэг.	Бүс нутаг тус бүр дэх нийгмийн оролцоо	Хүсэлтийн дагуу, шаардлагатай тохиолдолд	Exchange opinions through local administrative organizations
		Хөдөө орон нутгийн дижитал боловсролын төв	Тасралтгүй	Нутгийн захиргааны байгууллагаар дамжуулан санал солилцох. Дижитал хүртээмжтэй байдлыг бий болгохын тулд орон нутгийн оршин суугчид болон нийгмийн бүлэгтэй харилцах.
Зохицуулагч байгууллагууд	Бид хуулийг дагаж мөрдөн, үйл ажиллагаагаа зөв, зохистой байлгадаг	Санаачилгад оролцох	Шаардлагатай тохиолдолд	
Нийлүүлэгч	Бид харилцан итгэлцэл дээр тулгуурласан түншлэлийн харилцааг бий болгож, шударга, нээлттэй, зохистой бизнесийн үйл ажиллагаа явуулдаг.		Шаардлагатай тохиолдолд	



БАЙГАЛЬ ОРЧИН

Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах

Уур амьсгалын өөрчлөлт нь байгаль дэлхий болон хүн төрөлхтөнд аюул занал учруулж буй өргөн цар хүрээтэй асуудал бөгөөд үүнийг үр дүнтэй шийдвэрлэхийн тулд хувь хүмүүс, олон нийт, төрийн байгууллагуудын хамтын хүчин чармайлт шаардлагатай. Тиймээс уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах нь аливаа компанийн нийгмийн хариуцлага, тогтвортой байдалд чиглэсэн хүчин чармайлтын чухал хэсэг юм.

Юнител групп нь харилцаа холбооны компани, эрчим хүчний томоохон хэрэглэгч болохын хувьд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах үүргээ хариуцлагатайгаар ухамсарлаж байна. Хэдийгээр Монгол Улсын Засгийн газраас эрчим хүчний хэрэглээ болон хүлэмжийн хийн ялгарлыг хууль тогтоомжоор

зохицуулах арга хэмжээ авч байгаа ч дэд бүтцийн хангалтгүй хүртээмж, эрс тэс уур амьсгал, байгалийн хатуу ширүүн нөхцөл байдал нь нүүрсхүчлийн хийг бууруулах, улмаар тэглэхэд хүндрэл учруулж байна. Гэсэн хэдий ч бид хуучирсан тоног төхөөрөмжийг эрчим хүчний хэмнэлттэй шинэ технологиор солих, боломжтой тохиолдлуудад сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэвтрүүлэх гэх мэт боломжит бүх замуудаар хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахыг хичээн ажиллаж байна.

Юнител групп нь байгаль орчны тогтвортой байдлыг хангах арга барилаа сайжруулахыг тасралтгүй эрэлхийлдэг бөгөөд бид судалгаа, хөрөнгө оруулалт, худалдан авалт, төлөвлөлт, зураг төсөл, техникийн ажил зэрэг үйл ажиллагааныхаа бүх үе шат дээр байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэхийг эрмэлздэг. Мөн бид бүгдээрээ эх дэлхийгээ хайрлан хамгаалах үүрэгтэй гэдгээ ухамсарлаж, байгаль орчныг хамгаалах үйлсэд идэвхтэй оролцохыг ажилтнууддаа уриалахын зэрэгцээ байгаль орчинд эерэг нөлөө үзүүлж, хойч үедээ тогтвортой ирээдүйг үлдээхийг зорьж байна.

Эрчим хүчний хэрэглээ ба хүлэмжийн хийн ялгарлын тоо баримт 2022 онд:

Юнител группийн эрчим хүчний хэрэглээ **37,847 МВт.цаг**

Нийт хэрэглэсэн эрчим хүчний сервер, үндсэн станц болон үүрэн сайтуудын үйл ажиллагаанд зарцуулагдсан хувь **95%**

Нийт хэрэглэсэн эрчим хүчний сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс гарган авсан хувь **6%**

Юнител группийн ялгаруулсан хүлэмжийн хийн нийт хэмжээ **16,865 тонн CO₂**

Эрчим хүчний хэрэглээ ба хүлэмжийн хийн ялгарал (2022 vs 2021):

Хэмжигдэхүүн	Нэгж	2022	2021	Өсөлт
Цахилгааны хэрэглээ	МВт.цаг	37,847	28,293	34%
Мобайл сайтуудын цахилгааны хэрэглээ	МВт.цаг	29,426	20,801	41%
Дата төвийн цахилгааны хэрэглээ	МВт.цаг	6,643	6,601	1%
Оффисуудын цахилгааны хэрэглээ	МВт.цаг	1,778	891	100%
Сэргээгдэх эх үүсвэрээс үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүч	МВт.цаг	2,418	1,598	51%
Хүлэмжийн хийн ялгарал (scope 1&2)	тонн CO ₂	16,865	12,977	30%

Эрчим хүчний хэрэглээ болон хэмнэлт

Эрчим хүчний хэрэглээ

Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд манай компанийн эрчим хүчний хэрэглээ улс орны газарзүй болон эдийн засгийн онцлогтой уялдан зарим нэг хүчин зүйлээс шалтгаалан чулуужсан түлшний хэрэглээн дээр суурилдаг. Нүүрс, газрын тос, байгалийн хий зэрэг чулуужсан түлш нь Монгол улсын эрчим хүчний гол эх үүсвэр. Эрчим хүчний нэгдсэн сүлжээ нь голчлон нүүрс, байгалийн хийгээр тэжээгддэг бөгөөд эдгээр нь үйлдвэр, орон сууц, аж ахуйн нэгжүүдэд цахилгаан эрчим хүч нийлүүлэхэд ашиглагддаг. Манай дата төв болон үүрэн сайтууд дээрх үүсгүүрүүд эрчим хүчний нягтрал сайтай, найдвартай байдлын улмаас төрөл бүрийн салбарт өргөн хэрэглэгддэг дизель түлшээр ажилладаг.

Цахилгаан эрчим хүчний хэрэглээ нь манай компанийн үйл ажиллагааны чухал хүчин зүйл бөгөөд компанийн нийт эрчим хүчний хэрэглээний 99%-ийг цахилгаан эрчим хүч эзэлж байна. 2022 онд манай эрчим хүчний хэрэглээ өмнөх оныхтой харьцуулахад эрс нэмэгдсэн нь бид үйл ажиллагаагаа өргөжүүлсэнтэй холбоотой юм. Тасралтгүй өсөх 4G/5G сүлжээний эрэлтийг дэмжихийн тулд нэмэлт бааз станц болон үүрэн сайтуудыг шинээр байгуулсан. Мөн бид ажилтны болон бүтээгдэхүүний тоо, борлуулалтын өсөлтийг дагуулсан бизнесийн үйл ажиллагаагаа хөнгөвчлөх зорилгоор дундын (distributed) оффисуудыг ашиглалтад оруулсан.

Хүлэмжийн хийн ялгарал

Юнител группийн эрчим хүчний хэрэглээн дээр мэргэжлийн үнэлгээ хийлгэсний үр дүнд бид АНУ-ын ЕРА аргачлалыг ашиглан CO₂ (нүүрстөрөгчийн давхар исэл), CH₄ (метан), N₂O (азотын исэл)-ийн ялгарлыг хэмжин нийт хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолдог болсон.

Хэдийгээр эрчим хүчний хэрэглээ өссөн ч хүлэмжийн хийн ялгарал бага байгаа нь ажиглагдсан бөгөөд үүнийг бид сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт хөрөнгө оруулж, тоног төхөөрөмж, дэд бүтцээ сайжруулах зэргээр бүх үйл ажиллагаандаа анхаарч, илүү байгальд ээлтэй аргуудыг нэвтрүүлэх замаар эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх ажлуудыг тасралтгүй хийж гүйцэтгэж байгаатай холбоотой хэмээн үзэж байна

Эрчим хүчний хэмнэлттэй технологи

Бид эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмжийг сонгож ашиглахыг урьтал болгож, аливаа шинэ тоног төхөөрөмжийн эрчим хүчний ашиглалт, амьдралын мөчлөгийн үнэлгээг хийж, дотоод үйл ажиллагаандаа эрчим хүчийг үр ашигтай ашиглахыг зорьж байна. Техникийн өндөр үр чадвартай инженерүүд маань Дата төв болон үүрэн сайтууд дахь үндсэн үйл ажиллагааны оновчтой эрчим хүчний зарцуулалт, тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байна.



Дата төв

Бид Дата төвийн эрчим хүчийг хэмнэхийн тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Фреонд суурилсан эрчим хүчний хэрэглээг бууруулахын тулд серверийн өрөөнүүддээ агаараар хөргөх систем суурилуулсан. Гэхдээ агаараар хөргөх систем нь серверийн өрөөний чийгшлийн түвшинг стандарт хэмжээнээс буулгах магадлалтай тул 11-12-р саруудад агаарын хөргөлтийн системийн өдөрт ажиллах хугацааг тохируулж өгсөн.
2. Засварын ажлын хүрээнд бид ердийн бүх гэрлийг эрчим хүчний хэмнэлттэй LED гэрлээр сольсон. Ингэснээр эрчим хүчний хэрэглээ буурахаас гадна Дата төвийн гэрэлтүүлэг ч нэмэгдэх юм.

Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн хяналтаа сайжруулахын тулд бид эрчим хүчний менежментийн тогтолцоог нэвтрүүлэхээр зорьж байгаа бөгөөд энэ зорилгынхоо хүрээнд Дата төвд 2022 оны 7-р сард мэргэжлийн компаниар эрчим хүчний иж бүрэн аудит хийлгэсэн. Үүний үр дүнд хөдөлгөөнд мэдрэгчтэй гэрэл суурилуулах, хөргөлтийн системийн ажиллах горимыг дахин тохируулах зэргээр эрчим хүчний хэрэглээг илүү оновчтой болгох зөвлөмжүүд ирсэн бөгөөд үүнд үндэслэн 2023 оны Дата төв дээрх цахилгаан эрчим хүчний хэмнэлтийн төлөвлөгөөг гаргасан.



Мобайл сайтууд

Эрчим хүчний хэрэглээг илүү оновчтой болгохын тулд бид бааз станцууддаа эрчим хүч хэмнэх хэд хэдэн тохиргоог нэвтрүүлсэн ба үүнд үүрэн сайтуудыг агаараар хөргөх систем суурилуулах, хуучны эрчим хүчний хэрэглээ өндөртэй UPS-үүдийг илүү үр ашигтай, шинэ загвараар солих ажлууд багтсан. Эрчим хүчний үр ашгийг хамгийн өндөр түвшинд хүргэх зорилготой дэвшилтэт технологийг ашигласнаар үйлчилгээний чанараа алдалгүйгээр эрчим хүчний хэрэглээгээ бууруулж чадсан.

Бид үйл ажиллагаандаа сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх дорвитой алхмуудыг хийсээр ирсэн бөгөөд энэхүү зорилтынхоо хүрээнд 2022 онд нарны эрчим хүчээр бүрэн тэжээгддэг 216 үүрэн сайт байгуулсан нь өмнөх оныхоос 110%-аар өссөн үзүүлэлт юм.

Манай нарны эрчим хүчээр ажилладаг сайтууд нь эрчим хүчний төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох боломжгүй алслагдсан хөдөө орон нутагт байрладаг бөгөөд ингэснээр бид эдгээр бүс нутагт оршин суудаг хэрэглэгчдэд үйлчилгээгээ тасралтгүй үзүүлээд зогсохгүй сэргээгдэхгүй эрчим хүчний хэрэглээг бууруулах боломжтойг харуулж байгаа юм.

Бид нийт бааз станцуудын 10%-аас доошгүй хувийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй болгох богино хугацааны зорилгоо давуулан биелүүлж 2022 оны байдлаар мобайл сайтуудын 18.6% нь сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг болсон байна.

Ногоон эрчим хүчний хэрэглээ

2022 онд Юнител групп нь **50 тэрбум** төгрөгийн хөрөнгө оруулалтаар алслагдсан хөдөө орон нутагт нарны эрчим хүчээр ажилладаг **216 үүрэн сайтууд болон тэдгээрийн ойр орчмын дэд бүтцийг бий болгосон.**

Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэснээр **1,714 тонн CO2-той тэнцэх хэмжээний хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан.**

Хог хаягдлын менежмент

Юнител групп нь ажилтнууд болон олон нийтийг татан оролцуулсан үйл ажиллагаандаа, мөн ажлын байран дахь хог хаягдлыг зөв зохицуулах байдлаар хог хаягдлын менежментийг сайжруулах олон талт арга барилыг хэрэгжүүлдэг билээ.

Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, дахин боловсруулах боломжгүй хог хаягдлыг бууруулах зэргээр хог хаягдлын нэгдсэн тогтолцоог бий болгох, эрүүл, цэвэр орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хог хаягдлын оновчтой зохицуулалттай болохыг эрмэлзэж байна. Иймд бид хог хаягдлыг зөв зохицуулах, бохирдлоос урьдчилан сэргийлэх шилдэг туршлагауудыг үргэлж эрэлхийлж, хөрсөн дээрээ буулган хэрэгжүүлж, хог хаягдлыг бууруулах, аюулгүй устгах талаар олон нийтэд сурталчлах ажлуудыг мөн хийж гүйцэтгэж байна.


Мөн бид нийт ажилтнууддаа хог хаягдлын менежментийн талаар зөв ойлголт, мэдлэг өгөхөд анхаарч байгальд ээлтэй дадал хэвшлийг төлөвшүүлэх, хог хаягдлыг бууруулах боломжит аргуудыг танилцуулах сургалтуудыг тогтмол зохион байгуулж байна.



Электрон хог хаягдлыг бууруулах

Манай компани жил бүр цуглардаг электрон хог хаягдлын хэмжээг бууруулах зорилгоор бид үүрэн холбооны 5 сайтын 40 ширхэг хар тугалганы хүчлийн цэнэг хураагуурыг 10 ширхэг лити-ион цэнэг хураагуураар сольсон. Лити-ион цэнэг хураагуур нь хар тугалганы хүчлийнхтэй харьцуулахад жингийн хувьд хөнгөн бөгөөд удаан эдэлгээтэй байдаг тул тээвэрлэх, суурилуулахад хялбар, ойр ойрхон солих шаардлагагүй бөгөөд үүсэх хог хаягдлын хэмжээг бууруулах сайн талтай.

Нэг лити-ион цэнэг хураагуурын хүчин чадал нь хар тугалганы хүчлийн 4 цэнэг хураагууртай тэнцэнэ.



Мөн бид олон нийтийн хандлагыг судлахын тулд MCS группт харьяалагдах бүх компанийн ажилтнуудад электрон хог хаягдлыг

цуглуулах туршилтын аяныг зохион байгуулсан бөгөөд энэхүү аяны үр дүнд оролцогчдоос электрон хаягдал болох 200 гаруй төхөөрөмжийг цуглуулж чадсан.

Ажилтнуудын оролцоо

Бид “Өнгө нэм” ТББ-тай хамтран бүх оффисоо хог ангилан хаях савтай болгох ажлыг эхлүүлсэн. Мөн Дата төвд гадаа хог хаягдал ангилах цэгүүдийг бий болгосон ба үүнээс гадна хог хаягдлын тогтвортой зохицуулалтыг дадал болгохын тулд 2023 онд 1000 гаруй ажилтныг сургалтад хамруулахаар төлөвлөөд байна. Ажилтнууд энэхүү сургалтаас олж авсан мэдлэг, мэдээллээ гэр бүлийн гишүүддээ түгээж бидний эцсийн зорилго болох хог хаягдлыг бууруулахад бүх талууд оролцож, хог хаягдлын зөв менежментийг бий болгоход үнэтэй хувь нэмэр оруулна хэмээн харж байна.



Олон нийтийн оролцоо

Хог хаягдлыг бууруулах, үр дүнтэй зохицуулалт хийхэд олон нийтийн оролцоо, хандлага маш чухал үүрэгтэй. Иймд бид ажилтнуудынхаа үүрэг, оролцоог нэмэгдүүлэхийн тулд компанийн хог хаягдлаас эхлэн оновчтой зохицуулалт хийж, олон улсын жишиг, шинэ арга барилыг нэвтрүүлэн олон нийттэй ч мөн хамтран ажилладаг.



2022 онд бид нийт 160 ажилтан, Ерөнхий боловсролын сургуулийн ахлах болон дунд ангийн 650 сурагчийг хог хаягдлыг бууруулах, ангилах сургалтад хамруулсан. Үүний үр дүнд 59 кг электрон хог хаягдлыг цуглуулж, сургалтын явцад олж авсан мэдлэгээ олон нийтэд түгээх цахим контент бүтээсэн.

Үүнээс гадна бөс барааны хаягдлыг бууруулах, худалдан авах чадвар муутай өрхөд туслах зорилготой “Миний дүрэмт хувцас” кампанит ажлыг зохион байгуулсан. Энэ ажлыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан сургуулийн дүрэмт хувцасны хандивын аян зарлаж, хуучин дүрэмт хувцсаа авчирч өгсөн сурагчдад шинэ дүрэмт хувцсаа 15%-ийн хөнгөлөлттэй үнээр

авах ажлыг үйлдвэрлэгчидтэй хамтран зохион байгуулсан. Үр дүнд нь 500 гаруй дүрэм хувцас цугларч 10,000 тонн ус хэмнэж, 500 орчим кг бөс барааны хаягдал үүсэхээс сэргийлсэн.

Бөс бараа нь байгальд задралгүй 40 жил болдог ба зарим синтетик материал нь огт задарч, шингэдэггүй.



Байгаль болон зэрлэг ан амьтдыг хамгаалах



Харилцаа холбооны салбар нь олон улсын хэмжээнд хувь хүн, бизнесүүдийг хооронд нь зуучлахад гол үүрэг гүйцэтгэдэг билээ. Одоогоор салбарын байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл бага байгаа хэдий ч салбар хөгжихийн хэрээр байгаль орчин, зэрлэг ан амьтанд үзүүлэх нөлөөг харгалзан үзэх нь чухал байна. Тогтвортой хөгжлийн зорилгынхоо хүрээнд Юнител групп нь байгаль болон зэрлэг ан амьтдыг хамгаалах санаачилгыг дэмжин ажиллаж байна.

2022 онд бид 206 шинэ байршилд сүлжээгээ тэлсэн бөгөөд үүний ихэнх нь хүн ам цөөтэй, алслагдмал бүс нутаг байв. Шинээр суурилуулсан антенуудын 12 нь байгалийн цогцолбор газар, аялал жуулчлалын бүс, үндэсний парк болон биологийн олон янзын төрөл зүйлтэй газар байрласан.

Байршил бүрд 1 антен байгаа бөгөөд тэдгээр антенд цөөн хэдэн засвар үйлчилгээний ажилтнууд л очдог. Интернет болон үүрэн холбооны сүлжээ нь хөдөө орон нутагт нэвтэрснээр хүн амын өсөлтийг нэмэгдүүлэхэд тодорхой хэмжээний хувь нэмрийг оруулах хэдий ч тухайн бүс нутагт хүн амын тоо хэт цөөн, дэд бүтэц муугаас болж ойрын ирээдүйд байгаль болон зэрлэг амьтдад үзүүлэх нөлөө төдийлөн өөрчлөгдөхгүй байна.

Биологийн олон янз байдлыг хамгаалах санаачилга

Багахангай дахь шувууны үүр

ТЮнител групп 2022 онд Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголын шувуу судлалын нийгэмлэгтэй хамтран Багахангай дүүргийн биологийн олон янз байдлыг хамгаалах, тус нутаг дэвсгэрт махчин шувуудын тоо толгойг нэмэгдүүлэх замаар нутгийн тариаланчид, малчдын амьжиргааг дэмжих төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү санаачилгын хүрээнд эхний ээлжинд 30 шувууны байшин барихаар төлөвлөж байгаа бөгөөд энэ нь ойролцоогоор 120-150 махчин шувууны амьдрах орчинг бүрдүүлэх юм.



Төсөл амжилттай хэрэгжсэнээр хэт олширсон үедээ эргэн тойрны хөрс, ургамал, тариаланд хөнөөл учруулдаг үлийн цагаан оготно, монгол цагаан оготно зэрэг мэрэгч амьтдын тоо толгой буурна. Монголын махчин шувуу судлаачдын нийгэмлэг нь төслийн үр дүнг шувуу болон мэрэгчдийн тоо толгойн харьцааг тооцох замаар тогтмол хянаж байх юм.

Төсөл хэрэгжсэнээр:

- Хөнөөлтэй мэрэгчийн тоо толгойг одоогийнхоос 50% бууруулж, хангалттай доод



түвшинд барина.

- Тариалангийн газар болон бэлчээр нутгийг хамгаалж нутгийн малчин тариаланчдад дэмжлэг үзүүлнэ.
- Цөлжилтийг бууруулна
- Бүс нутгийн биологийн олон янз байдлыг хамгаална

Хөв цөөрөм

Юнител группийн инженер техникийн баг алслагдсан бүс нутагт сүлжээ нэвтрүүлэх, дэд бүтэц байгуулахаар ажиллаж байхдаа зэрлэг ан амьтан төдийгүй Дэлхийн байгаль хамгаалах



холбооны улаан номд бүртгэгдсэн амьтад ундны усаар хомсдож байгааг анзаарсан. Улмаар компанийн зүгээс зэрлэг байгалийг хамгаалах зорилгоор хөв цөөрмүүдийг байгуулж эхэлсэн бөгөөд энэ ажлын хүрээнд 2021 онд Говийн их дархан цаазат газарт эхний 3 цөөрмийг байгуулсан нь аргаль, янгир, цоохор ирвэс зэрэг амьтдад ундны усны амин чухал эх үүсвэр болсон. Энэ амжилтдаа тулгуурлан 2022 онд Монгол орны бүс нутгуудад зэрлэг амьтдыг хамгаалахаар дахин 4 цөөрөм байгуулж энэ талаар олон нийтэд сурталчлах ажлыг хийсэн нь 100,000 хүнд хүрсэн байна.

Олон нийтийн оролцоо

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Ногоон байгаасай” аяны хүрээнд Туул голын сав газар цэвэрлэх арга хэмжээнд энэ жил 1700 сайн дурын ажилтан хамрагдаж, Туул голын дагуух нийт 52 км газрын 200 тонн хог хаягдлыг цэвэрлэлээ. Энэхүү үйл ажиллагааны мэдээллийг олон нийтийн сүлжээнд контент болгон түгээсэн нь 100,000 хүнд хүрсэн байна.

Үүнээс гадна Юнителийн 155 ажилтан “My Club” ТББ-ын мод тарих, ой хамгаалах чиглэлээр мэргэшсэн 30 гишүүний дэмжлэгтэйгээр жил бүр зохион байгуулагддаг мод тарих өдөрт оролцсон. Шинээр тарьсан модны амьдрах чадварыг хамгийн оновчтой



болгох талаар тэдний өгсөн туршлага, зааварчилгааны үр дүнд 1,000 модыг амжилттай тарьж чадсан ба Хайрхан спорт клубийн удирдлагууд цаашид эдгээр модны арчилгааг хариуцан ажиллана.



- ☑ **1885** сайн дурын ажилтан байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах ажилд оролцсон.
- ☑ Туул голын **52 км** сав газрыг цэвэрлэсэн
- ☑ Харангадах аюулд өртөөд байсан **21,000** амьтанд хөв цөөрөм байгуулж ундны усаар хангасан.
- ☑ **1000** мод тарьсан



НИЙГЭМ

Олон талт онцлог болон ижил тэгш оролцоот байдал

Олон талт онцлог болон ижил тэгш оролцоот байдал нь Юнител группийн нийгмийн хариуцлагын үндсэн зарчмын нэг ба хүний нөөцийн менежментийн гол стратеги юм. Олон талт онцлог болон ижил тэгш оролцоот байдал нь өөр өөр үзэл бодол, амьдралын хэв маягтай хүмүүсийг нэг дор цуглуулан илүү тааламжтай, эрх тэгш компанийн соёлыг бий болгодог. Ялгаатай хүмүүсийг нэгтгэх нь аливаа асуудлыг олон өнцгөөс харах боломжийг дагуулж, шинийг эрэлхийлэх, бүтээлч байдлыг нэмэгдүүлдэг гэдэгт бид итгэдэг. Тиймээс бид ажилтан бүрийн өвөрмөц хэрэгцээ, үзэл бодол, чадавхыг хүндэтгэхийг чухалчилдаг ба найдвартай, хүртээмжтэй, аюулгүй ажлын байрыг бий болгохыг зорьж байна.

2022 онд Юнител групп нь олон талт онцлог байдал болон ижил тэгш оролцоот байдлыг дэмжих журмыг баталсан. Энэхүү журамд ялгаварлан гадуурхал болон аливаа дарамт шахалтыг цээрлэх, хүн бүрийн эрх тэгш байдлыг хангах, ажилтнуудын дунд найрсаг харилцааг бий болгох замаар ижил тэгш оролцоот бүхий компанийг төлөвшүүлэх үндсэн зохицуулалтыг тусгасан. Бидний үндсэн зарчим бол хувь хүн бүрийн үнэ цэнийг хүндэтгэж, нас, хүйс, арьсны өнгө, соёлын онцлог, тусгай хэрэгцээт эсэх, шашин шүтлэг, бэлгийн чиг баримжаа, үндэс угсаа, гэр бүлийн байдал, амьдралын түршлага, нийгэм-эдийн засгийн байдлаас үл хамааран хүн бүрд тэгш боломж олгох явдал юм. Батлагдсан журмыг компанийн дотоод мэдээлэл солилцох платформ болох U-Space дээрх ажилтнуудын гарын авлагад нийтэлсэн.

Юнител групп нь бүх шатны ажилтнуудыг компанийнхаа үнэт зүйл, зарчмыг хүндэтгээсэй гэж хүсэхийн сацуу ажилд авах, сургах, дэвшүүлэх, урамшуулах, тэтгэмж олгох зэрэг ажлын бүх үе шатад тэгш байдлыг баримтлахыг эрмэлздэг. Бид ажилтан бүрийн ялгаатай байдлыг харгалзан, тэдэнд өөрсдийгөө бүрэн илэрхийлэх боломжтой орчныг бий болгож, ажлын байр болгонд нийцсэн уян хатан ажлын нөхцөлийг бүрдүүлэхийг зорьж байна. Түүнчлэн, бид ажилтнуудаа нийгмийн амьдралд оролцох тэгш боломж, нөхцөлөөр хангадаг.

Бид ялгаварлан гадуурхах, гүтгэх, гутаан доромжлох, дарамтлах аливаа үйлдлийг тэвчихгүй ба ажилтан бүр бусдын эрх, эрх чөлөө, нэр төр, хувийн нууцыг хүндэтгэх үүрэгтэй. Ажилтан өөртэй нь шударга бусаар харьцсан, ялгаварлан

гадуурхсан гэж үзсэн тохиолдолд нэрээ нууцлан гомдол гаргах боломжтой сүвгийг бий болгосон.

SpeakOut

SpeakOut бол Юнителийн ажилтан, нийлүүлэгч, хэрэглэгчдэд ёс зүйн зөрчил болон шударга бус бизнесийн үйл ажиллагааны талаар Ёс зүйн хороонд чөлөөтэй мэдээлэх суваг юм. Энэхүү суваг нь шударга, зөв ажлын орчныг бүрдүүлэхэд ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх зорилготой. Бид ажилтнуудаа аливаа зөрчлийг үнэн зөв, бодитой байдлаар мэдээлж, компанийнхаа ёс зүйн хөгжилд хувь нэмэр оруулахыг дэмжин ажилладаг.

Юнителийн Ёс зүйн хороонд и-мэйл бичих, веб сайтаар хандах эсвэл дотоод сүлжээнд асуулга бөглөх зэргээр хандах боломжтой. Эдгээр сүвгээр дамжуулан ажилтнууд дараах төрлийн гомдлыг гаргаж болно. Үүнд:

- Ашиг сонирхлын зөрчил
- Ёс зүйн дүрмийн зөрчил
- Хууль, зохицуулалтын зөрчил
- Нөөц, бараа материал болон бусад хөрөнгийн зохисгүй ашиглалт

Бүх асуудлыг холбогдох хууль, зохицуулалтын хүрээнд шийднэ. Шүгэл үлээгч хүссэн тохиолдолд асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар Ёс зүйн хороо эргэн мэдэгдэнэ.

Олон талт онцлог ба ижил тэгш оролцоот байдлын стратеги төлөвлөгөө

Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт онцлог ба ижил тэгш оролцоот байдлыг нэмэгдүүлэх зорилго, зорилт болон тэдгээрийн хэрэгжилтийг үнэлэх арга хэмжээг тогтоодог. Удирдлагын баг нь эдгээр зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх стратегийг санал болгож, хэрэгжилтийг хариуцдаг.



Олон талт онцлог ба ижил тэгш оролцоот байдлыг хангах стратеги:

Богино хугацаанд

Тусгай хэрэгцээт хүмүүсийг дэмжин ажилд авах

Тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан ажлын байр бий болгох

Хүүхэд асрах чөлөөтэй байгаа ажилтнуудад зориулсан зайнаас ажиллах ажлын байр бий болгох

Сонгон шалгаруулалт хариуцсан ажилтнуудад ялгаатай хүмүүстэй хэрхэн ярилцлага хийх талаар сургалт орох

Дунд хугацаанд



Бүх ажилтанд тэгш байдлын талаар заавал хамрагдах сургалт орох

Олон талт онцлог бүхий ажлын хэсгүүдийг хэрхэн удирдах талаар сургалтыг удирдлагын багт орох

Урт хугацаанд

Ахмад настнуудыг ажилд авах боломжийг бүрдүүлэх

Олон үеийн төлөөллөөс бүрдсэн ажиллах хүчийг бий болгох



Түлхүүр зорилт: Бизнесийн ёс зүй болон ил тод байдлаар дамжуулан олон талт онцлог, ижил тэгш оролцоот бүхий ажлын байрыг бий болгох.

Хүйсийн тэнцвэртэй байдал

Ажилтнуудын дунд хүйсийн тэнцвэртэй байдлыг бий болгож хадгалах нь Юнител группийн олон талт онцлог ба ижил тэгш оролцоот байдлыг дэмжих хүрээний чухал стратегийн нэг юм.

Бид эрэгтэй болон эмэгтэй ажилтнуудын хоорондын цалингийн ялгааг бууруулах, нийгэмд эерэг нөлөө үзүүлэх зорилгоор удирдлагын түвшин дэх хүйсийн тэгш төлөөллийг нэмэгдүүлж эмэгтэй удирдагчдыг ажиллуулахад анхаардаг.

Эмэгтэй удирдлагын доор эмэгтэй ажилтнууд хүүхэд төрүүлэх, өсгөх зэрэг амьдралын чухал үедээ ч карьераа хөгжүүлж, үргэлжлүүлэн ажиллах урам зориг авна гэдэгт бид итгэдэг. Бид компани дахь хүйсийн тэнцвэртэй байдлын талаар албан ёсны статистик болон бусад мэдээллийн ил тод, нээлттэй, хүртээмжтэй байдлыг хангахыг эрмэлздэг.

Бид компанийн хэмжээнд хүйсийн тэнцвэртэй байдалтай холбоотой дараах зорилтуудыг тавьсан. Үүнд:

Нэгжийн удирдлагын түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь:

50%

Гүйцэтгэх удирдлагын түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь:

35%

ТУЗ-д эмэгтэйчүүдийн эзлэх хувь:

20%

Бид зорилтот түвшнийг 2022 амжилттай хангасан:

Нийт нэгжийн удирдлагын тоо / менежерүүд/: 152

Эмэгтэй менежер: 83
55%

Нийт гүйцэтгэх удирдлагын тоо /захирлууд/: 13

Эмэгтэй захирал: 5
38%

Нийт ТУЗ-ийн гишүүдийн тоо: 5

Эмэгтэй гишүүн: 1
20%

Нийт тусгай хэрэгцээт ажилтны тоо:

Нийт тусгай хэрэгцээт ажилтны тоо: 95

Бүтэн цаг: 8
8%

Гэрээт: 87
92%

Манай компани тусгай хэрэгцээт иргэдийг шаардлагатай ажлын байранд ажиллуулахыг эрмэлздэг. Одоогийн байдлаар хөдөлмөрийн хуулийн дагуу нийт ажилтны 4 хувийг тусгай хэрэгцээт иргэдээс бүрдүүлнэ гэсэн шаардлагыг хангахын тулд Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны гишүүдээс гэрээт үйлчилгээг авч ажиллуулж байна.

2023 онд бид тусгай хэрэгцээт иргэдийг ажиллуулж болох ажлын байрны тоог нэмэгдүүлэхийг зорьж байна. Хүртээмжтэй ажлын байр бий болгохын тулд тусгай хэрэгцээний шинж чанараас хамааран ажлын орчныг тохируулах, онцгой дэмжлэг үзүүлэх, шаардлагатай сургалтыг олгох, ажлын хамт олныг сургах шаардлага гарч болзошгүй байна. Энэ зорилгын хүрээнд бид ажлын байрандаа тусгай хэрэгцээт иргэдэд ээлтэй байдлын үнэлгээг гуравдагчаар хийлгэж байна. Үүнтэй холбогдуулан одоо ажиллаж байгаа тусгай хэрэгцээт ажилтнуудаас тэдний эрүүл мэнд, ажиллах орчин, ажлын цаг, хамтран ажиллагсадтай харилцах харилцаа болон бусад асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга замын талаар судалгаа авч байна. Судалгаанд хамрагдагсдад урьдчилан мэдээлэл өгч, зөвшөөрөл авсан ба оролцогчдын нууцлалыг чандлан хадгалж, цуглуулсан мэдээллийг зөвхөн судалгааны зорилгоор ашиглах болно.

*Тусгай хэрэгцээт буюу Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг ойлгоно. /Монгол улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 4 дүгээр зүйл/

Чадварлаг ажилтныг татах, тогтвортой ажиллуулах

Шинэ ажлын байр


Юнител групп нь зөвхөн бүтээгдэхүүн үйлчилгээ нийлүүлэхээс гадна шинэ ажлын байруудыг бий болгон улс орны эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулдаг. Хурдацтай инновац болон хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлагын эрин үед бид харилцаа холбооны дэлхийн шилдэг компаниудтай хөл нийлүүлэн алхаж, дэвшилтэт, үр ашигтай шийдлүүдийг тасралтгүйгээр нэвтрүүлэн, бизнесээ өргөжүүлэхийг зорьж байна. Компанийн зах зээлд эзлэх хувь нэмэгдэхийн хэрээр чадварлаг, найдвартай ажиллах хүчний хэрэгцээ мөн нэмэгдэж байна.

2022 онд Юнител групп нийт **294 шинэ ажлын байр** бий болгосон

Сонгон шалгаруулалт

Бид бүх хүнд хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг олгох нь тохирох үр чадвартай, тогтвортой ажиллах ажилтнуудыг татах үндсэн суурь болдог гэж итгэдэг. Бид компанийнхаа эрхэм зорилго, үнэт зүйл, зарчимд тулгуурласан системтэй, нарийн сонгон шалгаруулалттай гэдгээрээ олонд танигдсан билээ. Ажилтны сонгон шалгаруулалтдаа бид шударга ёс, эрх тэгш байдлыг хангаж, танил тал болон бусад давуу эрхээ ашиглахыг хориглодог. Ажлын байрны тодорхойлолт болон ажлын байрны зарыг нийтлэхдээ аливаа хувь хүний шинж чанарын (нас, хүйс г.м.) хувьд шаардлага тавьдаггүй. Бүх ажил горилогчид ямар нэгэн ялгаварлалгүйгээр сонгон шалгаруулалтын ижил үе шатуудыг давдаг.

Ажилд авах үе шат:



2022 онд Юнител групп нийт 750 ажилтан шинээр ажилд авсан

Чадварлаг мэргэжилтнийг татах



Юнителийн хүний нөөцийн баг нь өндөр чадвар, чадавхтай мэргэжилтнүүдээр баг бүрдүүлэхээр хичээн ажилладаг. Үүний хүрээнд бид компанийн үндсэн зорилго, үнэт зүйлд нийцсэн, өндөр үр чадвартай хүний нөөцийг илрүүлэх боломжтой төрөл бүрийн тэмцээн, уралдааныг ивээн тэтгэж байна (олимпиад, үр чадварын тэмцээн г.м).



Дадлага хийх боломж



Юнител Групп нь сурлагын өндөр амжилт гаргасан оюутнуудыг дадлага хийх боломжоор хангадаг. Бид дадлагажигч оюутнуудыг бүтээлч санаа, шинэ шийдлийг авчрах ундарга гэж үздэг ба гүйцэтгэл сайтай, хичээнгүй дадлагажигчдад сургуулиа төгсөх хүртэл цагаар ажиллах эсвэл сургуулиа төгссөний дараа гэрээт эсвэл бүтэн цагийн ажлын байр санал болгодог. Дадлагажуулах хөтөлбөр нь ирээдүйн ажилтан бэлдэх, тэр дундаа хэрэгцээ шаардлага өндөртэй, ховор мэргэжлээр ажилтан бэлдэх ач холбогдолтой үйл явц юм.

Явцын менежмент

Бидний гол ажлын нэг бол байнгын үнэлгээ, идэвхжүүлэлт, сургалтаар дамжуулан компанийн үйл ажиллагааг сайжруулах явдал юм. Бид ажилтнуудынхаа хичээл зүтгэлийг шударгаар үнэлж, өөрийгөө сайжруулах үйл явцыг нь дэмждэг ажлын байрыг бий болгохыг эрмэлздэг. Бид гүйцэтгэлийн удирдлагын системдээ үнэн зөв,

шударга зарчмыг баримталдаг бөгөөд энэ нь компани, нэгж, болон ажилтан бүрийн зорилго, зорилтыг тодорхойлох, хэрэгжүүлэх, явцыг хянах, гүйцэтгэлийг үнэлэх, шийдвэр гаргах, сайжруулах цогц үйл ажиллагаа юм.

Урамшуулал

Компанийн ажилтан бүрд гүйцэтгэлд суурилсан үнэлгээг хийдэг ба тухайн ажлын байрнаас шалтгаалан сард нэг удаа, хагас жилд нэг удаа эсвэл жилд нэг удаагийн давтамжтайгаар гүйцэтгэлийн үнэлгээг хийдэг байна. Үнэлгээ нь ажлын гүйцэтгэл эсвэл борлуулалтын гүйцэтгэлд тулгуурлан хийгддэг ба зарим ажилтнуудыг эдгээр хоёр үзүүлэлтийн аль нэгээр үнэлдэг бол зарим ажлын байрны хувьд аль алианаар нь үнэлдэг байна.

Ажилтны гүйцэтгэлийг үндэслэн шууд удирдлага нь хүний нөөцийн хэлтэстэй хамтран ажилтныг өөр ажилд шилжүүлэх, тушаал дэвшүүлэх эсвэл цалин, урамшууллыг нэмэх саналыг гүйцэтгэх удирдлагад хүргүүлдэг.

2022 оны 12-р сарын 31-ний байдлаар:


• **Нийт ажилтнууд 100% өөр өөрийн гүйцэтгэлд суурилсан урамшуулал авсан байна**

• **Нийт ажилтнуудын 12% нь гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн тушаал дэвшсэн.**

Авьяас, чадвараа хөгжүүлэх, карьераа өсгөх

Бид ажилтнууддаа өөрийгөө хөгжүүлэх, тасралтгүй сайжруулах хүсэл эрмэлзэл, хариуцлагыг суулгахыг хүсдэг. Жилийн эцсийн гүйцэтгэлийн үнэлгээний

үеэр ажилтнууд үр чадварын матриц дээр үндэслэн өөрсдийн бодит үр чадвар болон тухайн албан тушаалд шаардагдах үр чадварын хоорондын зөрүүг тодорхойлдог. Үүний дагуу жил бүрийн эхэнд шууд удирдлагууд өөрийн удирдлагын ажилтан бүрд нэгж, хэлтэс, компанийн зорилгод нийцсэн хувь хүний өсөлт хөгжлийг дэмжих ажлын төлөвлөгөөг боловсруулдаг. Уг төлөвлөгөө нь 70-20-10 зарчмыг баримталдаг.



Сургалтын хөтөлбөрүүд

MCS академи нь байгууллагын бүх түвшинд зориулсан хөтөлбөр боловсруулан гаргадаг ба манай ажилтнуудын сургалтуудын гол чиглүүлэгч юм.

- Манлайллын багц хөтөлбөр нь удирдлагын түвшинд тохирсон манлайллын үр чадварыг хөгжүүлэх замаар удирдах ажилтнуудыг бэлтгэдэг бөгөөд харилцан уялдаатай гурван багц сургалтаас бүрдэнэ.
- MCS менежментийн хөтөлбөр нь удирдлагын багийн гишүүдийн бизнесийн удирдлагын үр чадварыг хөгжүүлэх зорилготой.
- Хувь хүний хөгжлийн хөтөлбөр нь ажилтнуудын ерөнхий үр чадварыг хөгжүүлэх зорилготой бөгөөд үүнд хувь хүний менежмент, харилцааны үр чадвар, өөрийгөө илэрхийлэх, компьютерын үр чадвар, багаар ажиллах, манлайлах, багаар асуудал шийдвэрлэх зэрэг сэдвийн

хичээлүүд багтдаг. Ажилтан өөрийн хөгжлийн төлөвлөгөө, хэрэгцээгээ тодорхойлсны дараа уг сургалтад хамрагддаг.

- Менежерийн хөтөлбөр нь компанийн менежерүүд заавал үзэх ёстой хичээлүүдийг ("Гэрээний үндэс", "Санхүүгийн бус менежерүүдэд зориулсан санхүү", "Хүний нөөцийн бус менежерүүдэд зориулсан хүний нөөц", "Байгууллагын өөрчлөлтийн менежмент", "Сонгон шалгаруулалтын ярилцлага" г.м.) багтаасан байдаг.
- Нэгжүүдэд зориулсан хөтөлбөр нь компанийн гол нэгжүүдийн мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэхэд чиглэдэг. Одоогоор хүний нөөц, худалдан авалт, санхүү болон маркетингийн нэгжүүдэд зориулсан сургалтыг санал болгож байна.
- Ажилтны хөтөлбөр нь агуулахын, техникийн болон үйлчилгээний зэрэг сургалтад хамрагдах боломж хомс ажилтнуудад богино хугацаанд ерөнхий үр чадвар олгох хөтөлбөр юм.



2022 онд нийт 235
ажилтан 521 цагийн MCS
академийн сургалтад
хамрагдсан.

Үүнээс гадна бид хэрэглэгчтэй шууд
харьцдаг ажилтнууддаа бүтээгдэхүүн,
үйлчилгээний талаар сургалтыг дотооддоо
зохион байгуулдаг.

2022 онд нийт 590
ажилтан 171 цагийн
дотоод сургалтад
хамрагдсан.

Бид шинэ ажилтнууддаа зориулан
компанийн соёл болон дотоод дүрэм,
журмын талаар видео хичээлийг бэлтгэж,
дотоод мэдээлэл солилцох платформ болох
U Space-т байршуулсан.



2022 онд нийт 946
ажилтан 304 цагийн
Шинэ ажилтны сургалтад
хамрагдсан байна.

Мөн бид ажилтнууддаа Udemy, Coursera,
LinkedIn зэрэг онлайн сургалтын
платформуудаас үнэгүй сургалт, хичээл
үзэх боломжоор хангадаг

Ажилтныг тогтвортой ажиллуулах, хүний нөөцийн эргэц

Нийт ажлаас гарсан
ажилтнуудын талаас илүү
хувь нь эрүүл мэнд, гэр
бүлийн асуудал, сургуульд
суралцах, гадаадад
ажиллах зэрэг хувийн
шалтгаанаар ажлын байраа
орхисон байна.

Хүмүүн капиталыг амархан орлуулж болдоггүй.
Үнэ цэнтэй мэдлэг, туршлагатай ажилтнууддаа
алдах нь санхүүгийн алдагдалд хүргэхээс
гадна үлдсэн ажилтнуудын сэтгэл санаа, сэтгэл
ханамжид сөргөөр нөлөөлдөг. Бид ажилтнуудынхаа
тогтвортой ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэхийн
тулд ажлын цагийг шударгаар үнэлж, ажлын таатай
нөхцөлийг бүрдүүлж, ажил амьдралын тэнцвэрийг
бий болгоход нь дэмжлэг үзүүлж, ажилтнуудын
оролцоог дэмжих замаар тэдний аз жаргалтай
байдлыг хангах ёстой гэдгийг ойлгодог.

Цалин, урамшуулал

Цалин

Юнител групп нь ажилтнуудынхаа амьдралыг
сайжруулахын төлөө ямагт хичээж ажилладаг.
Бидний эрхэм зорилго бол нийгэм дэх орлогын
тэгш бус байдлыг бууруулах, ажилтнуудынхаа

амьжиргааны түвшин, худалдан авах чадварыг хадгалах, сайжруулах юм. Бид цалин, урамшууллын шударга тогтолцоог бий болгосон бөгөөд цалингийн хэмжээ нь нас, хүйс, хөдөлмөрийн чадвар алдалт, гэр бүлийн байдал, бие давхар эсэх зэрэг хувийн шинж чанараас үл хамаардаг. Бид улс орны эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалд нийцсэн өрсөлдөхүйц цалинг санал болгодог ба Монгол улсын хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийн дагуу нэмэлт олговрыг олгодог.

Юнител Группийн шинэ ажилтны цалин нь Монгол улсын засгийн газраас баталсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний **219.2%** -тай тэнцэж байна.

Жирэмсний болон амаржсаны амралт, эцгийн чөлөө

Юнител групп нь эрэгтэй болон эмэгтэй ажилтнуудаа гэр бүл, нийгмийн тэгш оролцоотой байхыг дэмждэг. Монгол улсын хөдөлмөрийн тухай хуульд зааснаар эмэгтэйчүүдийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг нийгмийн халамжийн сангаас олгодог бол шинээр төрсөн хүүхдийн эцэгт 10 хоногийн цалинтай чөлөөг компаниас олгодог. Тиймээс шинэ аавуудыг цаг зав гарган, гэр бүлийнхээ шинэ гишүүдэд анхаарал халамж тавихыг дэмжиж, амьдралынх нь энэхүү шилжилтийн үед шинэ аавуудад дэмжлэг үзүүлэх нь бидний үүрэг гэж үздэг.

Даатгал

Бид дараах даатгалыг зарим ажилчдад санал болгодог. Үүнд:

1. Тээврийн хэрэгслийн даатгал: бүх компанийн тээврийн хэрэгсэл болон бизнесийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй хувийн тээврийн хэрэгсэлд
2. Аяллын даатгал: гадаад болон дотоод томилолтоор явж байгаа ажилтнуудад
3. Ослын даатгал: компанийн багийн тамирчдад

Тэтгэмж

Бид ажилтнууддаа зориулан таатай, ая тухтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгынхоо хүрээнд, тодорхой урамшууллуудыг олгох замаар ажилтны сэтгэл ханамжийг нэмэгдүүлдэг.

2022 онд Юнител групп нийт 137 сая төгрөгийг нярай хүүхдийн ваучер, хүүхдийн баярын бэлэг, хуримын бэлэг зэрэг гэр бүлийн хэрэгцээнд чиглэсэн тэтгэмжүүдэд зарцуулсан байна.

Эрүүл ажилтан хөтөлбөр

Эрүүл хүмүүс аз жаргалтай байдаг. Бид ажилтнуудаа карьерын амжилт гаргаж, нийгмийн идэвхтэй амьдралтай, хайртай хүмүүстэйгээ цагийг өнгөрүүлдэг байгаасай гэж хүсдэг тул үргэлж анхаарал, халамж тавьдаг.

1. Биеийн эрүүл мэнд:

- а. Эрүүл мэндийн үзлэг. 2022 онд бид үндсэн ажилтнуудын 15%-ийг эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамруулсан. Хугацаат үзлэгийг (эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, лабораторийн шинжилгээ, ажилтан тус ажлын байранд тохирох эсэх үнэлгээ) албан тушаал, ажиллах нөхцөлтэй уялдуулан, Эрүүл мэндийн сайдын баталсан "Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийн журам"-ын дагуу зохион байгуулдаг. Дээрх дурдсан журамд заасан үзлэгт заавал хамрагдах ажлын байрнаас бусад ажилтнуудыг хоёр жилд нэг удаа компанийн зардлаар эрүүл мэндийн үзлэгт хамруулдаг.
- б. Улирлын томуугийн вакцин. 2022 онд нийт ажилтны 33%-ийг улирлын томуугийн вакцинд хамруулсан. Монгол улсад жил бүр тохиодог томуугийн дэгдэлт нь бусадтай харилцдаг, дундын оффист ажилладаг ажилтнуудад ихээр нөлөөлдөг тул бид бүх оффисууд дээр томуугийн вакцинжуулалтыг зохион байгуулсан.
- в. Е-Клиник. Бид бүх ажилчдадаа цахим эмчийн үйлчилгээг хямдралтай үнээр авах боломжийг олгосон.
- д. Бариа засал эмчилгээ. МХҮХ-той байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд бид ажилтнууддаа бариа заслын эмчилгээний эрхийн бичиг олгосон /ажилтан бүрд 2/.
- е. Фитнес болон иогийн төвд хөнгөлөлттэй явах эрх. /10 фитнес болон иогийн төв

2. Сэтгэл зүйн эрүүл мэнд.

Дуудлагын төв болон техникийн ажилтнуудын дунд сэтгэл зүйн эрүүл мэндийн талаар ойлголтыг дээшлүүлэх арга хэмжээ авсан.

- а. Бид дээр дурдсан зорилтот бүлгийн ажилтнуудыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд сэтгэл зүйн эрүүл мэндийн үзлэгт хамруулах, урьдчилан сэргийлэх эмчилгээ хийлгэх боломжоор хангасан
- б. Дундын оффисын ажилтнуудад сэтгэл зүйн эрүүл мэндийн асуудлуудыг шийдвэрлэх аргыг бий болгох үүднээс "1 минутын удиртгалтай амьсгалах" бясалгалын техникийг заасан.
- в. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмч нарын дэмжлэгтэйгээр Бизнес хөгжил төлөвлөлтийн хэлтсийн ажилтнуудад сэтгэл зүйн эрүүл мэндийн сургалт зохион байгуулсан.



Ажилтанд ээлтэй орчин

Бид ажилтнуудынхаа сэтгэл санаа, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхийн тулд хамгийн таатай ажлын орчныг бүрдүүлэхийн төлөө түүштай ажилладаг. Бидний нэн тэргүүний зорилт бол ажил амьдралын тэнцвэрийг хадгалахад хамгийн тохиромжтой нөхцөлийг бүрдүүлэх явдал юм.





Дундын оффис 2022 оны 9-р сараас эхлэн манай ажилтнууд Улаанбаатар хотын баруун, зүүн, өмнөд, хойд гэсэн дөрвөн бүсэд байршилтай шинээр нээгдсэн дундын оффисуудаас сонгон ажиллах боломжтой болсон. Ингэснээр зөвхөн нэг нэгдсэн оффист баригдаж, оргил ачааллын цагаар Улаанбаатар хотын замын түгжрэлд цаг заваа үрэхгүйгээр гэрээсээ алхаад очих боломжтой байршлыг сонгон ажиллаад үлдсэн цагаа гэр бүл, хувийн хөгжил, амралт зэрэгт зарцуулах боломжтой болж байгаа юм.

Уян хатан ажлын цаг Мөн бид уян хатан ажлын цагийг чухалчилдаг. Ажилтнууд ажил үүргээсээ хамааран 07:00-10:00 цагийн хооронд ажилдаа ирж, 16:00-19:00 цагийн хооронд тарах боломжтой. Ажлын найман цагийг гүйцээхдээ ажилтнууддаа ажилд ирэх, тарах цагаа сонгох эрх чөлөөг олгодог.

Компанийн соёл

Ажилтны оролцоо Бид ажилтнуудаа Юнителд ажиллах хугацаандаа үнэ цэнтэй харилцаа тогтоож, хамт олны халуун дулаан уур амьсгалыг мэдрэмжийг мэдрээсэй гэж хүсдэг. Бид янз бүрийн арга хэмжээ, хөтөлбөрүүдээр дамжуулан ажилтнуудаа ажлын болон ажлын бус цагаар стрессээ тайлан цагийг үр ашигтай болон хөгжилтэй өнгөрүүлэх боломжоор хангахыг эрмэлздэг.

Баг бүрдүүлэх /teambuilding/ хөтөлбөрүүд:




Бүх ажилтны уулзалт. Бид жил бүр өнгөрсөн жилийн амжилтаа дүгнэж, ирэх жилийн зорилго, зорилтоо хэлэлцэхээр цугладаг.

Шинэ ажилтны нетворкинг. Бид энэхүү хөтөлбөрөөр дамжуулан шинэ ажилтнууддаа бие биетэйгээ танилцах, дасан зохицох боломжийг олгодог.

Воркшопууд. Хэлтсүүд багийнхаа идэвх, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор жилд 2 удаа workshop зохион байгуулдаг.

Ажилтны оролцоо:



Супер гэр бүл. Бид ажилтнуудынхаа чөлөөт цагийг спорт урлагтай холбож, хөгжилтэй өнгөрөөх зорилгоор ажилтнуудаа нийт 16 супер гэр бүлд хувааж, сард 2 удаа тэмцээн зохион байгуулдаг. 2022 онд бид ширээний хөл бөмбөг, дартс, 3х3 сагсан бөмбөг зэрэг тэмцээнүүдийг зохион байгуулсан. Үүнээс гадна Е-спорт болон Лудогийн аваргуудаа шалгаруулсан. Харин урлагийн авьяастай ажилтнууд Open Mic арга хэмжээний үеэр тайзан дээр өөрсдийн авьяас чадвараа харуулсан юм.



Хүүхдийн баяр. 6-р сарын 1-нд ажилтнуудынхаа хүүхдүүдийг аав, ээжийнхээ ажилтай танилцан цагийг дурсамжтай өнгөрүүлэхээр Хүүхдийн баярыг зохион байгуулсан.



Хөгжмийн наадам. Жил бүр бид Мэдээллийн технологи, харилцаа холбооны ажилтны өдрийг өргөн дэлгэр тэмдэглэдэг. 2022 онд Монгол шилтгээнд Coachella-тай төсөө бүхий хөгжмийн наадам зохион байгуулсан.




Shine on. Шинэ жилийн баярыг аж ахуйн нэгжүүд болон ажилтнууддаа санхүүгийн дарамт шахалт үзүүлж тэмдэглэдэг хуучинсаг уламжлалыг эвдэж, бид Монголын анхны оффисын Зул сарын баярыг зургаан байршилд нэгэн зэрэг зохион байгуулсан компани болсон.

Хөдөлмөрийн аюулгүй байдал

Юнител групп нь өөр өөр ажлын нөхцөл, эрсдэл дагуулдаг олон тооны мэргэжилтнүүдийг удирддаг. Ажилтнууд болон түншүүддээ аюулгүй ажлын орчин бүрдүүлэх нь бидний үүрэг бөгөөд бидний гол аюулгүй байдал, эрүүл ахуйн хүрээн дахь зорилт бол ажлын байранд гарах ослыг тэг рүү дөхүүлэхийг зорих юм.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо

Бид Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг зохицуулдаг. Мөн бид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцооны ISO45001 стандартыг нэвтрүүлэхээр ажиллаж, үнэлгээ, төлөвлөлтийн үе шатанд явж байна. Одоогоор бид дээр дурдсан стандарттай уялдуулан бодлого, журмыг сайжруулан боловсруулж байна.



Аюулгүй байдал, эрүүл ахуйн зохион байгуулалтын бүтэц

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл нь гүйцэтгэх захирал, ХАБЭА-ын нэгж, компанийн хэмжээнд өндөр эрсдэлтэй нэгжүүдийн менежерүүд зэрэг 13 гишүүнээс бүрддэг. Зөвлөл нь жилд нэг удаа хуралдаж компанийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцооны гол асуудлууд болон зорилт, стратегийг тодорхойлдог. ХАБ-ын инженер, эрүүл ахуйн мэргэжилтнээс бүрдэх ХАБЭА-ын нэгж нь компанийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэрэгжилт, менежментийг хариуцдаг.


Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ

ХАБЭА нэгж нь ажлын байран дээр түгээмэл тулгардаг өндөр эрсдэлтэй нөхцөлүүдийг агуулсан 19 шалгуураар ажлын байрны эрсдэлийн үнэлгээг бүх ажлын байруудад хийдэг. Эдгээр шалгуур үзүүлэлтүүдээр ажлын байр тус бүрд үнэлгээ өгч хамгийн өндөр оноотойгоос нь урьдчилан сэргийлэх, хугацаат эрүүл мэндийн үзлэгт хамруулах, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА) сургалтад хамруулах, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл олгох зэрэг эрсдэлийг бууруулах арга хэмжээ болон эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааны үеэр чухалчлан авч үздэг.

Бид ажилтнуудынхаа эрүүл мэндтэй холбоотой мэдээллийн нууцлалыг чандлан хадгалдаг ба ажилтан эрүүл мэнд, аюулгүй байдлын хөтөлбөрт хамрагдсан эсэх нь ажилтныг ажлаас чөлөөлөх, тушаал буруулах, тушаал дэвшүүлэх, эд зүйл санал болгох, нөхөн олговор олгох зэргийн үндэслэл болохгүй.

33 төрлийн ажлын байр нь өндөр эрсдэлтэй нөхцөлийнх учир энэ ажлын байранд ажилладаг ажилтнууд жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамрагддаг.

51 төрлийн ажлын байранд алба хашиж буй ажилтнууд өдөр тутам аюулгүй ажиллагааны зааварчилгаа авдаг.



Эрсдэлийг бууруулах

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт

Бид 2022 онд тохирох ажилтнуудад дараах сургалтуудыг олгосон. Үүнд:

- Өндрийн аюулгүй ажиллагаа
- Цахилгааны аюулгүй ажиллагаа
- Сэрээт ачигчийн операторын гэрчилгээтэй сургалт
- Барилга, цахилгаан шатны аюулгүй байдал
- Сайн сайхан байдал ба эрүүл мэнд
- Худаг доторх аюулгүй байдал
- Хийн аюулгүйн ажиллагаа

2022 онд бид нийт 1313
цагийн хөдөлмөрийн
аюулгүй байдлын
сургалтыг 627
ажилтанд орсон.

Гамшгийн сургууллт

Жил бүрийн 3-р сарын сүүлийн Пүрэв гарагт бид өөрсдийн бүх оффист гамшгийн сургууллт (гал болон газар хөдлөлт) зохион байгуулдаг.

Хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналт, шалгалт

2022 онд бид хөдөлмөрийн аюулгүй байдлын дараах хяналт, шалгалтуудыг хийсэн. Үүнд:

- Бүх оффис, Дата Төв болон агуулахад галын аюулгүй байдлын шалгалт. Шалгалтын үр дүнд тулгуурлан ХАБЭА нэгж нь:
 - Галын аюулгүй байдлын төлөвлөгөөг шинэчилж, сайжруулсан;
 - Галын дохиоллын системүүдийг сайжруулсан;
 - Аюултай тоног төхөөрөмж болон зөөврийн генератор, батарей зэрэг шатамхай хатуу биетийг хэрэглэх, хадгалах зааварчилгааг боловсруулсан.
- Нэг бүрийн хамгаалах хэрэгслийн шалгалт. Шалгалтын үр дүнд суурилан ХАБЭА нэгж нь шаардлагатай сайжруулалтуудыг хийсэн.
- Компанийн 20 тээврийн хэрэгсэлд дотоод аюулгүй байдлын хяналт, шалгалт хийсэн. Хяналт, шалгалтын үр дүнд тулгуурлан ХАБЭА нэгж нь:
 - 129 доголдол илрүүлж, арилгасан (Үүнд баримт бичиг болон засвар үйлчилгээ багтана);
 - Жолоочийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг шинэчилж, сайжруулсан;
 - Ослын даатгалын процессыг хянаж, сайжруулж, автоматжуулсан
- Улаанбаатар хотын оффис болон салбаруудын ундны усанд шалгалт хийсэн. ХАБЭА нэгж нь:
 - Ус хадгалах савыг стандартын дагуу ариутгуулсан;
 - Ундны усанд жил бүр хийгддэг химийн болон бактериологийн шинжилгээ хийсэн.

Ажилтны үүрэг, хариуцлага ба оролцоо

Бид ажилтнуудаасаа холбогдох хууль тогтоомж, зохицуулалт, дотоод бодлого, журам, зааврыг чанд мөрдөн, компанийн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн менежментийн тогтолцоог хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцоотой байх шаардлагыг тавьдаг. Ажилтнууд ажлын байран дээрээ учирч болзошгүй эрсдэлийг ухамсарлаж, хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалт, гамшгийн сургууллт, эрүүл мэндийн үзлэг зэрэг компанийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдан, эрсдэлээс сэргийлэх шаардлагатай. Бид мөн ажилтнуудаа ХАБЭА-н тухай хуульд заасны дагуу ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, осол, осолд дөхсөн тохиолдол, өвчин эмгэг зэргийг илрүүлэх, мэдээлэхэд хамтран ажиллахыг байнга сануулдаг.

Туслан гүйцэтгэгч нарын аюулгүй байдал, эрүүл ахуй

Бид туслан гүйцэтгэгчийг ажлын байр, хөдөлмөрийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж, ажилчдаа аливаа гэмтэл, эрүүл мэндийн эрсдэлээс хамгаалахын тулд холбогдох бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гэсэн хүлээлтийг тавьдаг.

2022 онд бид туслан гүйцэтгэгчид дагаж мөрдөх үүрэн холбооны технологи суурилуулах аюулгүй ажиллагааны зааврыг боловсруулсан. ХАБЭА-н нэгж нь 19 туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн 80 ажилтанд аюулгүй ажиллагааны 6 удаагийн сургалтыг зохион байгуулаад байна. Бид мөн туслан гүйцэтгэгчдийг ХАБЭА-н үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг сар бүр ирүүлэхийг шаардаж эхэлсэн.

Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтүүдс

Бид компанийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гүйцэтгэлийг үнэлж, ТҮЗ-д тайлагнах гол түлхүүр үзүүлэлтүүдийг гаргадаг.

Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтүүд

Нийт
мэдээлсэн
ослын хувь
(TRIR):

0.2*

хуанлийн нэг жилд бүтэн цагийн 100 ажилтанд ногдох бүртгэгдсэн осол болон өвчлөлийн тоо

Ажлаас
чөлөөлөгдсөн,
хязгаарласан
эсвэл шилжүүлсэн
өдрүүд (DART):

2.08*

хуанлийн нэг жилд бүтэн цагийн 100 ажилтанд ногдох тохиолдлын үр дүнд нь ажлаас чөлөөлөгдөх, ажлыг хязгаарлах, эсвэл шилжүүлэх шаардлагатай болсон ослын тоо

Алдагдсан
цагийн хувь
(LTC):

9.8*

хуанлийн нэг жилд бүтэн цагийн 100 ажилтанд ногдох ажлын цаг алдсан тохиолдлын тоо (ажилтан бүтэн ээлжээр ажиллах боломжгүй болсон аливаа ажлаас шалтгаалсан гэмтэл, өвчин)

2022 онд нийт 8 ажлын байрын осол бүртгэгдсэний 2 нь ажил үүргээ гүйцэтгэж байхдаа авто замын осолд орсон, 2 нь ажилдаа ирж явахдаа халтирч унасан, 4 нь компанийн спортын тэмцээний үеэр гэмтсэн байна. Ижил төрлийн осол дахин гарахаас сэргийлж осол бүрийн дараа бид зохих анхааруулга, зааварчилгаа, зөвлөгөөг ажилтнуудад и-мэйлээр хүргүүлсэн

* Бүх гүйцэтгэлийн үзүүлэлтийг 200,000-аар үржүүлнэ (40 цагийн ажлын долоо хоногт үндэслэн 100 ажилтан 50 долоо хоногт ажиллах нийт цаг)

* Бүртгэгдсэн тохиолдлууд нь ажлын байр, нөхцөл, явцаас үүдэлтэй бүх нас баралт, гэмтэл, өвчлөл

Сүлжээ болон мэдээллийн аюулгүй байдал

Интернэт, технологийн хурдацтай хөгжлийг дагаад технологийн цоорхойг ашиглан мэдээллийг хялбархан олж авах, дэд бүтцийг нь эвдэх шинэ ухаалаг хэрэгслүүд бий болж, бизнес болон үндэсний аюулгүй байдалд заналхийлж байна. Тиймээс бид мэдээллийн системдээ хамгийн сүүлийн үеийн хамгаалалтын шийдлүүдийг нэвтрүүлэхээс гадна болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэхийн тулд ажилтнуудаа мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр сургах, мэдлэг олгоход анхаарч байна.



ISO27001 сертификат

Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг шинэчлэн сайжруулсан нь

2022 онд бид ISO27001 Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны (МАБМТ) сертификатыг авахыг зорьсон ба энэ зорилгынхоо хүрээнд Юнител групп мэдээллийн аюулгүй байдлын багц бодлого болон холбогдох журмуудыг шинэчилж, стандартад нийцүүлэх томоохон хэмжээний төслийг хэрэгжүүлсэн юм.



Энэхүү төслийн хүрээнд бид өмнө мөрдөж байсан бодлогоо эргэн хянаж, МАБМТ-ны манай байгууллагад тохирох шаардлагуудыг тодорхойлсон. ОУСБ-ын шаардлагад нийцсэн баримт бичиг боловсруулахын тулд бид итгэмжлэгдсэн гуравдагч талаас зөвлөх үйлчилгээ авсан. Мэдээллийн аюулгүй байдлын нэгж нь бодлогыг холбогдох ажилтнуудад танилцуулах, хэрэгжилтийг хангах үүрэг хүлээн ажиллаж байна.

Манай компанийн үйл ажиллагаа үр дүнтэй байх, хэрэглэгчдэд бүтээгдэхүүн үйлчилгээгээ хүргэхэд мэдээллийн бүрэн бүтэн байдал чухал ач холбогдолтой. Юнител групп нь хувь хүн, ажилтан, түнш, нийлүүлэгчийн хувийн мэдээллийн нууцлалыг хамгаалах үүрэг, хариуцлагаа бүрэн ухамсарладаг. Хэдийгээр Мэдээллийн технологийн газар нь мэдээллийн аюулгүй байдлын системийг бий болгох, гадаад, дотоод аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийн үнэлгээ хийх, тэдгээр эрсдэлүүдийг арилгах, бусад технологийн шийдлүүдийг хэрэгжүүлэх үүрэгтэй ч компанийн ажилтан бүр мэдээллийн аюулгүй байдлын бодлого, журмыг дагаж мөрдөн, болзошгүй эрсдэлийг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

Бодлогыг хэрэгжүүлэх

Мэдээллийн аюулгүй байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх аян

Мэдээллийн аюулгүй байдлын нэгж нь "Мэдээллийн аюулгүй байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх аян"-ы хүрээнд ажилтнууддаа сургалт, анхааруулга, зөвлөмж өгөх замаар компанийн хэмжээнд мэдээллийн аюулгүй байдлын талаарх мэдлэг, ойлголт, соёлыг төлөвшүүлэх чиглэлээр ажилладаг. Энэхүү аяны хүрээнд дараах ажлуудыг хийж, гүйцэтгэсэн. Үүнд:

- Мэдээллийн аюулгүй байдлын онлайн сургалт болон видео сургалтын материалыг боловсруулж, компанийн дотоод мэдээлэл солилцох платформ болох U Space-д байршуулсан.
- Мэдээллийн аюулгүй байдлын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, болзошгүй аюул заналыг ажилтан, хэрэглэгчдэд таниулах зорилгоор подкаст бэлтгэж, Юнителийн Facebook хуудсанд байршуулсан.
- Мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой асуулт хариултын тэмцээн зохион байгуулсан.
- Улирал тутам ажилтнуудад фишинг и-мэйл илгээж симуляци хийсэн. Ажилтнуудын мэдээллийн аюулгүй байдлын талаар мэдлэгийг залилан мэхлэх үйлдлийг амжилттай илрүүлсэн ажилтны тоонд үндэслэн жилд 2 удаа дүгнэдэг. Симуляцид тэнцээгүй ажилтнуудад давтан сургалт олгодог.
- Шинээр ажилд орсон мэдээллийн технологийн инженерүүдэд улирал тутамд заавал хамрагдах сургалт ордог.

2022 онд

1272 ажилтан
Мэдээллийн
аюулгүй байдлын
сургалтын хуудсаар
зочилсон

400 гаруй
ажилтан
INFOSEC асуулт,
хариултын
тэмцээнд
оролцсон

43 шинээр
ажилд орсон
мэдээллийн
технологийн
инженер сургалтад
хамрагдсан

4309
фишинг и-мэйл
симуцляцаар
ажилтнуудад
илгээгдсэн

Аюулгүй байдлын
шалгалтыг
ажилтнуудын
80%
нь амжилттай
давсан

Технологийн шийдэл

Жил бүр бид туршлагатай гуравдагч тал болох Nettitude-ээр мэдээллийн системийн техникийн болон эрсдэлийн үнэлгээ хийлгэдэг. Үнэлгээний үр дүнд үндэслэн засах арга хэмжээг авч илэрсэн эрсдэлүүдийн 80%-ийг залруулсан.

2022 онд бид серверийн халдлагаас сэргийлэх болон эцсийн цэгийн хамгаалалтын системээ сайжруулсан. Бид сервер дээрээ аюулаас урьдчилан сэргийлэх систем бүхий Check Point Next Generation Firewall-г суулгасан бөгөөд эцсийн цэгүүдийнхээ 100%-н хамгаалалтын системийг сольсон. Мөн компанийн сүлжээн дэх аливаа тасалдлыг илрүүлж, мэдээлэх бодит цагийн хяналтын системийг нэвтрүүлсэн. Эдгээр шинэ нэвтрүүлсэн системүүдтэй холбоотойгоор мэдээллийн технологийн инженерүүдийг сургалтад хамруулсан.

2022 онд

Эцсийн цэгүүдийн
100%-д хамгаалалтын
систем шинээр
суурилуулсан

Систем, сүлжээний
төхөөрөмж, датабазыг
100% хяналтын
системд холбосон.

Цахим боловсрол ба ижил тэгш оролцоо

Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа компанийн хувьд бидний үйл ажиллагааны эцсийн зорилго нь хүмүүсийг хооронд нь холбох юм. Орон даяар сүлжээгээ өргөжүүлж, интернэт болон гар утасны үйлчилгээ үзүүлэхээс гадна хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, цахим боловсролыг олгох нь бидний үүрэг хариуцлага гэж бид хардаг.

Хандив

Энэ хариуцлагын хүрээнд бид орон нутагт цахим хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор компьютер хандивлаж, интернэтийн үнэгүй үйлчилгээ үзүүлсэн. Үүнд:

- Дархан хотын 2 Ерөнхий Боловсролын Сургуулийн 2800 гаруй сурагч, ажилтнууд ашигладаг мэдээллийн технологийн лаборатори, номын сан, багш нарын өрөөг өргөн зурвасын интернэтийн үйлчилгээгээр үнэ төлбөргүй хангасан
- Австралийн Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн төгсөгчдийн холбоо, Зориг сантай хамтран хэрэгжүүлж буй Охид, эмэгтэйчүүдийг чадавхжуулах төслийг дэмжих зорилгоор Сонгинохайрхан дүүргийн олон нийтийн төвд үнэгүй интернэт үйлчилгээ нэвтрүүлсэн. Тус төв нь 8000 хүн амтай 38-р хорооны эмэгтэйчүүд болон улсын 106, 123-р сургуулийн сурагчдад үйлчилдэг.
- Баянгол дүүргийн олон нийтийн сургалтын төв болон Дорноговь аймгийн Сайншанд хотын дунд сургуульд компьютер хандивласан.



Боломжийг хүн бүрд

Юнител HUB төв

Бид HUB-ын Хүн амын сан, Women in Tech, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран Дархан хотод Юнител HUB төвийг нээсэн. Энэхүү төв нь Дархан-Уул аймгийн залуучуудад тав тухтай суралцах орчинг бий болгож, цахим ном, компьютер, таблет ашиглан цахим боловсролын үйлчилгээг авах боломжийг бүрдүүлсэн юм.

Тус төв нь робот бүтээх, код бичих зэрэг хүүхдүүдэд зориулсан сургалтыг зах зээлээс хямд үнээр заадаг. 2022 оны 6-р сард ашиглалтад орсноос хойш сар бүр дунджаар 287 хүүхэд тус төвийн үйл ажиллагааны үр шимийг хүртэж байна. Энэ тоо маш хурдацтай нэмэгдэж байгаа бөгөөд төслийн хүрээнд орон нутгийн 9000 иргэнд үйлчлэхээр төлөвлөж байна.

Юнител групп нь цаашид Монгол Улсын 21 аймагт HUB төв байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд 2023 онд тэдгээрээс 10 төвийг ашиглалтад оруулахаар ажиллаж байна.



Боломжийг хүн бүрд

Үйлчилгээний хүртээмжтэй байдал

Алслагдсан байршлуудыг холбох


Монгол улс нь дэлхийн хамгийн сийрэг хүн амтай орны нэг бөгөөд, энэ нь алслагдсан бүс нутагт амьдарч буй иргэдэд зайлшгүй шаардлагатай зарим үйлчилгээг үзүүлэхэд хүндрэл учруулдаг. Алслагдсан бүс нутагт амьдарч байгаа иргэдийн хувьд ерөнхий боловсролын сургуулиас бусад насанд хүрэгчдийн боловсролын төв, номын сан, олон нийтийн төв зэрэг боловсролын үйлчилгээ авах боломжгүй байдаг. Харин интернэтийн үйлчилгээ нэвтэрснээр энэ зөрүүг арилгах боломжтой юм. Эдгээр хүмүүст харилцаа холбоо нь зөвхөн боловсрол болон тэгш боломжийг олгохоос гадна хайртай хүмүүстэйгээ харилцах, нийгмийн нэг хэсэг гэдгээ мэдрэх, урам зориг авах, зугаацах боломжийг олгох юм.

Цахим шилжилтийн энэ эрин үед бид хэнийг ч ардаа үлдээхгүйн тулд алслагдмал

бүс нутагт **205 антен** шинээр суурилуулж, сүлжээгээ өргөтгөөд байна. Хөдөө орон нутгийн **39 салбарын 10 нь алслагдмал бүс** нутгийн хэрэглэгчдэд үйлчилж байгаа ба эдгээр салбаруудаар жилд нийт **150,000** гаруй хүн үйлчлүүлж байна.

Саад, бэрхшээлийг арилгах

Цахим шилжилтийн эрин үед ганц ч хэрэглэгчийг ардаа хоцроохгүй байх зорилгодоо хүрэхэд газар зүйн алслагдмал байдал нь цорын ганц саад байсангүй. 2022 онд бид олон талыг хамруулах дээр илүү анхаарч, нөөц бололцоогоо хүртээмжтэй байдлаар хуваарилж эхэлсэн.



Хамгийн эхэнд бид үндсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний зааварчилгаагаа хадмал тексттэй болгож, үйлчилгээний багтаа дохионы хэлний орчуулагч нэмж ажиллуулж байна. Үндсэн салбаруудад тодорхой бүлгийн хэрэглэгчид

(жирэмсэн, тусгай хэрэгцээт, ахмад настай гэх мэт) дараалалгүй үйлчлүүлэх цонх нэмсэн. Үүнээс гадна манай UniMusic үйлчилгээ (дуут дохионы үйлчилгээ) нь дуудлага хүлээн авагч нь сонсголын бэрхшээлтэй тул зөвхөн мессежээр харилцах боломжтой болохыг мэдээлдэг хонхны дуутай болсон. Хурдацтай өөрчлөгдөж буй цахим орчинд дасан зохицож, амьдралынхаа туршид ашиглаж байснаас огт өөр төхөөрөмж ашиглаж сурах нь өндөр настай хүмүүст бэрхшээлтэй байдаг. Бид Дархан хот дахь Юнител HUB төвд “Хамтдаа хөгжье” Ахмадын баярын өдөрлөгийг зохион байгуулсан ба уг өдөрлөг дээр орон нутгийн 70 гаруй ахмад настнуудад гар утасны хэрэглээ, мэдээллийн аюулгүй байдал, сэтгэцийн эрүүл мэнд, иогийн сургалтууд орсон байна. Дээрх арга хэмжээ нь хэдийгээр жижиг боловч бид эдгээр хүчин чармайлтаа тууштай өргөжүүлж, улсын хэмжээнд өөрчлөлт оруулахаар зорьж байна.



Нийгэмд тустай ажлууд

Сайн дурын ажил

Бид ажилтнуудаа нийгмийн сайн сайхны төлөө дугарах хүчтэй хоолой гэдэгт итгэдэг бөгөөд нийгэмд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах боломжийг нь олгохыг эрмэлздэг.



Цусны хандив: 70 ажилтан цусаа хандивласны үр дүнд 180 хүний амь аврах хэмжээний цус цугларсан.

2022 онд манай ажилтнууд дараах сайн дурын ажлыг хийсэн байна. Үүнд:



Мод тарих өдөрлөг (Байгаль орчин > Байгаль, зэрлэг ан амьтдыг хамгаалах хэсгээс үзнэ үү)



“Жаргалтай, гайхалтай”: Юнителийн нийт ажилтнуудыг хамруулсан бэлгийн хайрцгийн аяны хүрээнд хөдөө орон нутгийн 400 хүүхдэд ном, өвлийн хувцас гэх мэт шинэ жилийн бэлэг цуглуулсан.



Олон нийтэд мэдээлэл хүргэх: SMS Broadcast

Бид харилцаа, холбооны үйлчилгээ үзүүлэгчийн хувьд өөрсдийн боломжид тулгуурлан төрийн болон төрийн бус байгууллагуудад тусламж үзүүлэхэд хэзээд нээлттэй байдаг билээ. Бид тэдгээр байгууллагуудтай үндэсний хэмжээнд дэлгэрсэн маркетингийн платформ, харилцаа холбооны дэд бүтцээ ашиглан тулгамдсан асуудлын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх замаар хамтран ажилладаг.

2022 онд бид төрийн байгууллагуудын дараах кампанит ажлуудыг дэмжин ажилласан. Үүнд:

- “5 минут”, хүүхдийн зам тээврийн ослын эрсдэлийг бууруулах кампанит ажил (110,000 хэрэглэгчдэд мессеж илгээсэн)
- Улаанбаатар хотын Байгаль орчны агентлагаас хэрэгжүүлсэн хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх кампанит ажил (нийтийн сүлжээнд 100,000 хандалт авсан)
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтарсан Эх Дэлхийн өдөр

кампанит ажил (байгаль орчноо хамгаалах талаар 1,100,000 мессеж илгээсэн)

- Үндэсний онцгой байдлын удирдлагын газартай хамтран зохион байгуулсан Онцгой байдлын сургуулилт (60,000 текст мессеж илгээсэн)
- Замын цагдаагийн газартай хамтран зохион байгуулсан жолоо барих үед гар утас ашиглах аюулын талаар кампанит ажил

Эдгээр болон бусад олон кампанит ажлын хүрээнд бид олон нийтэд **2.37 сая орчим зурвас илгээсэн.**



ЗАСАГЛАЛ

Засаглалын дээд түвшин

Компанийн засаглал

Юнителийн Захирлуудын зөвлөл (ТУЗ) нь компанийн стратеги, бизнесийн зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэх бололцоог бүрдүүлэх сайн засаглалын түршлага болон бүтцийг барьж ажилладаг. Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-ийн гишүүдийг тухайлсан мэдлэг, түршлагад нь үндэслэн нэр дэвшүүлдэг. ТУЗ болон түүний дэргэдэх хороод нь ТУЗ-ийн журам болон хороодын дүрмийн дагуу улиралд нэг удаа хуралддаг ба ээлжит бус хурал зарлаж болох бөгөөд шаардлагатай үед бичгээр санал авч болдог.

2022 онд ТУЗ 1 удаа биечлэн, 3 удаа цахим хурал хийн, нийт 4 удаа хуралдсан байна.

Юнител группийн ТУЗ дараах гишүүдээс бүрддэг:



Р.ГАНБОЛД



АТТИЛА ВИТАЙ



Л.ГАНТӨМӨР



Б.АРИУНАА



Г.МЯГМАРЖАВ



С.ЦЭНГЭЛ

ТУЗ-н хуралдааны тэмдэглэл, тогтоолууд:

	Нийт
Тогтоол	45 (Англи хэл дээр; бүртгэлийн зорилгоор шаардлагатай бол монгол хэл рүү орчуулсан)
Хуралдааны тэмдэглэл	20 (ТУЗ болон ТУЗ-н дэргэдэх хороодын хуралдааны)
Бусад баримт бичиг	61 (Мэдэгдэл, бодлого журам, гэрээ)

ТУЗ ба хороодын олон талт онцлог байдал:

Захирлууд болон хорооны гишүүдийг холбогдох хууль тогтоомж, ТУЗ-н журмын дагуу нэр дэвшүүлж, сонгон шалгаруулдаг.

	Нийт гишүүд	Эмэгтэй гишүүд	Хараат бус гишүүд
ТУЗ (орлох захирлыг оруулаад)	6	1	1
Аудит, эрсдэлийн хороо	3	1	1
БОНЗ-ын хороо	4	1	1
Санхүү, хөрөнгө оруулалтын хороо	3	1	0
Цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хороо	3	1	1

ТУЗ-өөс дараах хороодыг холбогдох асуудлын хүрээнд шаардлагатай тохиолдолд шалгалт хийх, зөвлөгөө өгөх зорилгоор байгуулсан. Үүнд:

ТУЗ-ын хороод	Үүрэг	Баримт бичиг	Хорооны дарга
Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо	Удирдах ажилтныг нэр дэвшүүлэх болон тэдний цалин урамшууллын бодлогыг компанийн гүйцэтгэлийн үрт болон богино хугацааны зорилгууд, хүний нөөцийн менежментийн стратегитай уялдаатай байхад хяналт тавих, түүний хэрэгжилтийг хангах	Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороон дүрэм	Л.Гантөмөр
Аудит болон эрсдэлийн хороо	<ul style="list-style-type: none"> Группийн санхүүгийн тайлан, хөндлөнгийн болон дотоод аудитын чанар, шударга байдлыг хянах. Хууль эрх зүй, зохицуулалтын орчны комлаенсийг хангах Эрсдэлийн удирдлага, бодлогын хяналт болон группийн стратегийн эрсдэлийг удирдах 	Аудит болон эрсдэлийн хороон дүрэм	Б.Ариунаа
БОНЗ-н хороо	<ul style="list-style-type: none"> Групп компаниудын үйл ажиллагаа, группийн БОНЗ-ын бодлого болон холбогдох хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг хянах Групп компаниудын мэдээллийн аюулгүй байдлын бодлого, систем, хяналтын үр дүнтэй байдлыг удирдах 	БОНЗ-н хороон дүрэм	Аттила Витай
Санхүү, хөрөнгө оруулалтын хороо	Групп компаниудын богино болон урт хугацааны санхүүгийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон санхүүгийн үзүүлэлтүүдийг хянах	Санхүү, хөрөнгө оруулалтын хороон дүрэм	Г.Мягмаржав

Сайн засаглал

Ашиг сонирхлын зөрчил

Ашиг сонирхлын зөрчлийн бодлогын дагуу компанийн ТУЗ-ийн гишүүд, удирдлагууд болон бүх худалдан авалтын ажилтнууд өөрсдийн боломжит болон бодит ашиг сонирхлын зөрчлийг мэдүүлэх үүрэгтэй. 2022 онд ТУЗ-ийн түвшинд 2 ашиг сонирхлын зөрчил мэдүүлсэн ба эдгээр захирлууд ТУЗ-ын журмын дагуу санал өгөхөөс татгалзсан.

Бизнесийн ёс зүй

Юнител групп нь ёс зүйн дээд хэм хэмжээг тогтмол баримталж, дотоодын болон олон улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу үйл ажиллагаагаа явуулахыг эрмэлздэг. Юнителийн бизнесийн ёс зүйн практик нь “Ёс зүйн дүрэм”-д тусгагдсан байдаг. Тус дүрэм нь ажилтнуудыг үүргээ гүйцэтгэх явцдаа зөв шийдвэр гаргахад чиглүүлж, тохирох хууль, журам, компанийн дотоод бодлого байхгүй тохиолдолд ч ёс зүйтэй, үндэслэлтэй шийдвэр гаргахыг шаарддаг. Бид өөрсдийн баримталдаг зарчмаа эрхэмлэж, жил бүр нийт ажилтнууддаа ёс зүйн дүрмийн сургалт явуулдаг.

2022 онд ТУЗ-өөс дараах бодлого, журмыг шинэчлэн баталсан. Үүнд:

1. Ёс зүйн дүрэм
2. Ёс зүйн шалгалтын журам
3. Авлигын эсрэг бодлого, журам
4. Мөнгө угаахын эсрэг бодлого, журам

Түүнчлэн, бид гуравдагч этгээд болон гэрээт гүйцэтгэгчдэд хамаарах Ёс зүйн дүрэм, БОНЗ-ын бодлогыг баталж, веб сайт дээрээ олон нийтэд нээлттэй байршуулсан.

Авлигын эсрэг

Юнител нь ажилтнууд болон хамтран ажиллаж байгаа гуравдагч талын аливаа хэлбэрийн авлигыг ямагт хүлээн зөвшөөрөхгүй. Авлигын эсрэг бодлого болон бодлогын хэрэгжилттэй холбоотой журам нь ёс зүйн доод хэм хэмжээг тогтоох, авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангах, группийн хэмжээнд авлигын эрсдэлийг тогтмол бууруулах зорилготой. Ёс зүйн дүрэмд заасны дагуу ажилтнууд аливаа нөхцөл байдалд авах зөв арга хэмжээг мэдэхгүй эсвэл тухайн нөхцөл байдал нь авлига, хээл хахуулийн шинж чанартай эсэх нь тодорхойгүй байвал Комплаенсийн багтай холбогдохыг нэн тэргүүнд зөвлөдөг. Түүнчлэн Юнител бэлэг, үзвэр үйлчилгээ, төрийн дэмжлэг болон сайн үйлсийн хандив болон комплаенсийн хяналт, шалгалт шаардлагатай бусад үйл ажиллагааг бүртгэх “Star Compliance” системийг нэвтрүүлсэн. 2022 оны байдлаар Комплаенсийн нэгж бүх бэлэг болон үзвэр үйлчилгээг хянаж, Ёс зүйн дүрмийн дагуу 1 бэлгийг буцаасан байна.

Шүгэл үлээх

Болзошгүй зөрчлийн талаар ажилтнууд өөрийн шууд удирдлага, хүний нөөц эвэл холбогдох албан тушаалтанд шууд мэдэгдэхэд хүндрэлтэй байгаа тохиолдолд ашиглах боломжтой Спийк Аут (SpeakOut) мэдээлэх сувгийг бий болгосон. Бид мэдээлэгчийн нууцлалыг чандлан хадгалдаг бөгөөд ажилтны эсрэг ямар нэгэн сахилгын арга хэмжээ авахыг хатуу хориглодог. Бид дараах Спийк Аут (SpeakOut) сувгуудаар мэдээлэл хүлээн авдаг:

Утас	+976-88882027
Вэб хуудас	http://speakout.mcs.mn
E-mail	speakout@mcs.mn

2022 онд Ёс зүйн дүрэм зөрчигдсөн байж болзошгүй талаар нийт 8 мэдээлэл хүлээн авсан ба эдгээрийг Ёс зүйн зөрчлийг хянан шалгах дотоод журмын дагуу бүрэн хянан шалгаж, 100% шийдвэрлэн Аудит болон эрсдэлийн хороонд тухай бүр тайлагнасан.

Зохицуулалтын комплаенс

Комплаенс хариуцсан дэд захирал нь Комплаенсийн нэгжийн хамт группийн хэмжээнд зохицуулалтын комплаенсийг хариуцдаг. 2022 оны байдлаар Юнител групп болон түүний охин компаниудад ямар нэгэн торгууль ногдуулаагүй болно.

Ханган нийлүүлэгчдийн менежмент

Тогтвортой байдлын эрсдэлийг бууруулах зорилгоор бид байгаль орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагаа явуулдаг ханган нийлүүлэгчдийг дэмжихийг зорьдог.

2022 онд бид компанийнхаа үнэт зүйлсийг өөрсдийн ханган нийлүүлэгчдэд түгээхийн тулд тэдэнд тавих үндсэн шаардлагыг агуулсан “Нийлүүлэгчийн ёс зүйн дүрэм”-ийг боловсруулсан. Бид тогтвортой болон хариуцлагатай бизнесийн үйл ажиллагааг эрхэмлэж, ханган нийлүүлэгчдээсээ ил тод, ёс зүйтэй бизнесийн үйл ажиллагаа эрхэлж,

эрүүл аюулгүй ажиллах орчноор хангах, шударга цалин хөлс олгох замаар ажилтнуудынхаа сайн сайхан байдлыг нэн тэргүүнд тавихыг шаарддаг. Мөн бид ханган нийлүүлэгчдээ нүүрсхүчлийн хийн ялгарал болон түүний нөлөөллийг бууруулах замаар уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэж бидний хүчин чармайлтад нэгдэн тогтвортой ирээдүйн төлөө хамтран ажиллахыг

2022 оны 12 сарын 31-ний байдлаар

уриалдаг билээ. М-Си-Эс Холдинг нь ханган нийлүүлэгчдийн байгаль орчин ба нийгмийн үнэлгээний явцыг оновчлон өөрийн болон охин компаниудын нийлүүлэлтийн сүлжээг үр дүнтэйгээр хянах зорилгоор ханган нийлүүлэгчдийн нэгдсэн порталыг хөгжүүлж байна.

Нийт ханган нийлүүлэгчийн **92%-ийг** дотоодын ханган нийлүүлэгчид* эзэлж байна.

*Монголд үйл ажиллагаа явуулдаг ханган нийлүүлэгчид.

Тайлангийн тухай

Тайланд өөрөөр тусгаагүй бол энэхүү Юнител группийн Тогтвортой байдлын тайлан нь 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс 2022 оны 12-р сарын 31-ний өдрийн хоорондох байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын гүйцэтгэлийн тоо баримтыг нарийвчлан тусгасан бөгөөд санхүүгийн тайланг орлохгүй болно.

Энэхүү тайлангийн агуулга нь БОНЗ-ын нөлөөллийн дотоод үнэлгээнд үндэслэсэн бөгөөд Олон улсын тайлагналын санаачилга (GRI) болон толгой компанийн боловсруулсан тогтвортой байдлын хэмжүүрийн дагуу бэлтгэгдсэн. Толгой компани болон охин компаниуд нь БОНЗ-ын асуудлыг хэрхэн авч үзэж, шийдвэрлэдэг талаар Тогтвортой байдлын дэлгэрэнгүй тайланг тусад нь бэлтгэн гаргадаг болно.

Мэдээллийн үнэн зөв байдал.

Энэ тайланд тусгагдсан мэдээллийг дотоод баталгаажуулалтын журмын дагуу баталгаажуулсан бөгөөд хөндлөнгөөс бичгээр нотлох шаардлагагүй болно.

Санхүүгийн бус тайлагналын тухай.

Санхүүгийн бус мэдээлэл нь мэдээллийн онцлог, тодорхойлох арга барилын хязгаарлагдмал байдлаас үүдэн хэмжлийн эргэлзээг агуулж байгаа болно. Энэхүү тайланд тусгагдсан зарим мэдээлэл нь хэмжлийн эргэлзээтэй тул таамаглал дээр үндэслэн гаргасан болно. Хэмжилтийн ялгаатай ч хүлээн зөвшөөрөгдөхүйц арга барилуудыг хэрэглэснээр өөр үр дүнтэй хэмжигдэхүүнүүд гарч болох бөгөөд хэмжилтийн өөр арга барилуудын нарийвчлал нь ялгаатай байж болно.

Таамаглалууд.

Энэхүү тайланд тогтвортой байдлын зорилго, зорилт, амлалт, хөтөлбөр, бизнес төлөвлөгөө, санаачилгын ирээдүйн гүйцэтгэлийг одоогийн таамаглал, хүлээлтэд үндэслэн гаргасан болно. Эдгээр мэдээллүүд нь ихэвчлэн “хүсэх”, “зорих”, “таамаглах”, “итгэх”, “хүргэх”, “тооцоолох”, “хүлээх”, “боломжтой”, “төлөвлөх”, “стратегийн”, “зорилт”, “зорилго” болон төстэй үг хэллэгийг агуулсан байна. Ирээдүйн бодит үр дүн, тэр дундаа зорилго, зорилт, амлалтын үр дүн нь нөхцөл байдлын өөрчлөлт, тодорхойгүй байдал, мөн өөр бусад хүчин зүйлсээс шалтгаалан бидний төлөвлөсөн үр дүнгээс өөр байх боломжтой. Эдгээр ирээдүйг таамагласан мэдээлэл нь зөвхөн тайлан гарах өдрийн байдлаар гарсан тул хөрөнгө оруулагчид аливаа шийдвэрийг эдгээр мэдээллүүд дээр үндэслэхгүй байхыг

сануулья. Юнител нь мэдээлэл шинэчлэгдэх, ирээдүйд тохиолдох үйл явдал зэрэгтэй холбогдсон ирээдүйг таамаглах мэдэгдлүүдийг шинэчлэх үүрэг хүлээхгүй. Тайланд өөрөөр тусгаагүй тохиолдолд энэхүү тайлан нь Юнител ХХК-ийн 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс 2022 оны 12-р сарын 31-ний хоорондох дотоод үйл ажиллагааг хамарсан болно. Энэхүү тайлан нь Олон улсын тайлагналын санаачилга (GRI)-ын Ерөнхий зарчмуудын (Core option) дагуу бэлтгэгдсэн.



Юнител группийн 2022 оны

Тогтвортой байдлын **ТАЙЛАН**

Холбоо барих
www.unitel.mn

